**СЭЛЭНГЭ АЙМГИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН**
**ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 10 сарын 12 өдөр                Дугаар 49                Сүхбаатар сум

Үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “а”, 19 дүгээр зүйлийн 19.1, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.2, 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар батлсугай.

2.Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, аймгийн нийт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлан таниулах, биелэлтийг бүтэн жилээр гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга /Ш.Оэгил/-д даалгасугай.

ДАРГА                Г.БЯМБАА

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

| | Д/д | Үндэслэсэн дунд хугацааны бодлогын баримт бичиг | Аргахэмжээ | Шалгуур үзүүлэлт | | Хүрэх үрдүн | Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, хөрөнгийн эх үүсвэр | Хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | **Одоогийн байдал** \Суурь түвшин\ | **Хүрэх түвшин** \2019 оны жилийн эцсийн байдлаар\ | | | |
| **НЭГ.ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| **1.1 Хөдөө аж ахуйн бодлого, шинэчлэлийн хүрээнд:** | | | | | | | | |
| **Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицсон цогц, ухаалаг хөдөө аж ахуйг хөгжүүлж эрүүл, аюулгүй хүнсний хангамжийг сайжруулна.** | | | | | | | | |
| 1 | 1 | АЗДҮАХ-ийн 1.1.1 | Тариаланчдын зөвлөгөөн, үзүүлэх сургалтыг зохион байгуулах | Жил бүр уламжлалт арга хэмжээг зохион байгуулж байна. | 2019 оны тариалалт, ургац хураалтын технологийн талаар нэгдсэн чиглэл тодорхойлогдож, хэрэгжсэн байна. | Үр тариа 235.0 мянган тн, төмс 35.0 мянган тн, хүнсний ногоо 32.0 мянган тн, таримал тэжээл 20.0 мянган тн, тосны ургамал 18.5 мянган тн-ыг тус тус бэлтгэсэн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ХХААГ |
| 2 | 2 | ЗГҮАХ-ийн 2.18 | "Атрын гуравдугаар аян"-ны үргэлжлэл, "Мах, сүүний анхдугаар аян"-ыг эрчимжүүлэх | Мах, сүүний анхдугаар аяныг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2017 оны А/206 дугаар захирамжаар 37 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. | Тариалангийн үйлдвэрлэлийн техникийн парк шинэчлэл, үрийн хангамж, таримал тэжээлийн үйлдвэрлэл нэмэгдэж, мал эрүүлжүүлэх арга хэмжээг авч, өндөр ашиг шимт хээлтэгч, хээлтүүлэгчээр хангагдсан байна. | Аяны хүрээнд үйлдвэрлэсэн үр тариа, төмс, ногоо, мах, сүүний хангамж тогтворжиж, эрт ургацын ногооны хангамж нэмэгдсэн байна. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ХХААГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | 3 | АЗДҮАХ-ийн 1.1.2 | Төмсний үр хадгалах, аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх зоорь, агуулахыг барих ажлыг эхлүүлэх | Аймгийн хэмжээнд жилд хураан авч байгаа төмс, хүнсний ногооны 60 орчим хувьйиг хадгалж байна. | Аймгийн аюулгүйн өвс тэжээлийн нөөцийг хадгалах агуулах, төмс хадгалах зоорьтой болсон байна. | Иргэдийн төмсний үрээр хангах нөхцөл боломж бүрдэж, өвс тэжээлийн нөөцийг хадгалахтай болсон байна. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ХХААГ, ААНБ |
| 4 | 4 | АЗДҮАХ-ийн 1.1.4 | Төрөл бүрийн эрдэс болон органик бордооны хангамжийг нэмэгдүүлж, хэрэглээг тогтворжуулан, хөрсний шим тэжээлийг сайжруулах | Хөрсний шим тэжээлийн бодисын алдагдал ихсэж байна. | Төрөл бүрийн эрдэс болон органик бордооны хангамжийг нэмэгдүүлж, шингэн бордооны хөрсний шим тэжээлийг нэмэгдүүлсэн байна. | Хөрсний шим тэжээл нэмэгдсэн талбайн нэгж га-аас авах ургацын хэмжээ нэмэгдсэн байна. | Аж ахуйн нэгжүүдийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ХХААГ, ААНБ |
| 5 | 5 | АЗДҮАХ-ийн 1.1.16 | Мах, сүүний Сэлэнгэ, Казакын цагаан толгойт, Халимаг, Хар, улаан ангусын цэвэр үүлдрийн хээлтэгч, хээлтүүлэгчээр хөнгөлөлттэй үнээр хангах ажлыг зохион байгуулах | 2018 онд малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 268,8 сая төгрөгийн 588 үржлийн үхрийг 9 сум, 6 тосгоны 60 өрхөд олгосон. | 2019 онд “Герефорд” үүлдрийн 20, ангус үүлдрийн үржлийн 20 үхрийг иргэдэд нийлүүлсэн байна. | Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч өрхийн тоо 40-өөр нэмэгдсэн байна. | Аж ахуйн нэгжүүдийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ХХААГ, ААНБ |
| 6 | 6 | АЗДҮАХ-ийн 1.1.19 | Мал эмнэлгийн технологит үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, малын эмч нарын мэдлэг чадвар, хариуцлагыг өндөржүүлэн, мал эмнэлгийн | Аймгийн Засаг даргын 2018 оны А/132 тоот “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ явуулах тухай” захирамжаар мал эмнэлгийн бүхий л төрлийн ажил | Мал эмнэлгийн үйлчилгээг технологит хугацаанд чанартай хэрэгжүүлж, зарим онош тодорхойгүй өвчнийг нарийн мэдрэмжтэй багаж хэрэгслийн тусламжтайгаар | Эрүүл ахуйн шаардлага хангасан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдсэн байна. | Улсын төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ХХААГ, МЭГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | лабораторийг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах | үйлчилгээг жилийн туршид тасралтгүй хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. | оношилж, мал амьтны элдэв өвчингүй тайван байдлаа хадгална. Малын эмч нарыг бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | | | |
| 7 | 7 | АЗДҮАХ-ийн 1.1.19 | Хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, боловсруулалт, гарал үүсэл, хадгалалт, тээвэрлэлт, тариалангийн талбайд хэрэглэж байгаа химийн бодисд тавих хяналтыг сайжруулах | Хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн горим алдагдаж эрүүл ахуйн шаардлага хангахгүй байна. | Хүнсний бүтээгдэхүүн мах, ногооны хадгалалт, тээвэрлэлтэд хяналт шалгалт хийж, зөрчил дутагдлыг арилгасан байна. | Хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлага хангагдана. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ХХААГ, МХГ |
| 8 | 8 | АЗДҮАХ-ийн 1.1.16 | "Эрчимжсэн үхрийн аж ахуй" аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, үр дүнг тооцох | Үхэр сүргийн тоо толгой 2010 онтой харьцуулахад 52.2 хувиар өсч 74.9 мянган толгойд хүрсэн. Иргэдийн үхэр өсгөх идэвх санал санаачлага нэмэгдэж, ууараг ихтэй таримал тэжээлийн хэрэгцээ ихсэж байна. | Хөтөлбөр хэрэгжсэнээр үхэр сүргийн тоо толгой 5 хувиар нэмэгдсэн байна. | Эрчимжсэн үхрийн аж ахуй эрхэлснээр иргэдийн ашиг орлого нэмэгдсэн байна. | Улсын болон орон нутгийн төсөв, зээл тусламж, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ХХААГ |
| 9 | 9 | Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 131 | "Малын таримал тэжээл" аймгийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх | Мал сүргийн эрчимжүүлэхэд таримал тэжээлийн хэрэгцээ өсч байна. 2018 онд | Тариалангийн эргэлтийн талбайн сэлгээний 5-аас доошгүй хувьд тэжээлийн ургамал | Нэг малаас авах махны гарц, ноос ноолуурын хэмжээ нэмэгдэж, | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ХХААГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дүгээр тогтоол | | 15.0 мянган га-д таримал тэжээл тариалсан. | тариалж малын тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлсэн байна. | иргэдийн ашиг орлого нэмэгдсэн байна. | | |
| 10 | 10 | Монгол Улсын Засгийн газрын 76 дугаар тогтоол | Монгол Улсад атар газар эзэмшиж, газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсний 60 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах | Аймгийн хэмжээнд “Атар-60” бүтээлч ажил өрнүүлэх аймгийн салбар хэсгийг байгуулан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулсан. | Салбарын эрдэмтэд, тариаланчдын оролцоотой “Атар-60” онол үйлдвэрлэлийн бага хурал зохион байгуулагдсан байна. | Сэлэнгэ аймгийн газар тариалангийн хөгжлийн цаашдын бодлого чиглэл тодорхойлогдсон байна. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг сумдын ЗДТГ, ХХААГ |
| 11 | 11 | Монгол Улсын Засгийн газрын 76 дугаар тогтоол | Хөдөө аж ахуйн “FARM” үзүүлэх сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах | Хөдөө аж ахуйн нэгжүүд FARM – үүдэд салбар чиглэлийн сургалт, зөвлөгөөн хийгдэж байгаагүй. | Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн хослуулан хөгжүүлсэн томоохон аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцсан байна. | Олон нийтэд орчин үеийн олон талт цогц хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн ололт, үр дүнг олон нийтэд хүргэсэн байна. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ |
| 12 | 12 | ЗГҮАХ-ийн 2.18 | “Сэлэнгэ төмс хүнсний ногоо”, “Жимс жимсгэнэ” хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган үр дүнг тооцох | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 60 дугаар тогтоол “Сэлэнгэ төмс хүнсний ногоо” хөтөлбөр, Жимс, жимсгэнэ хөтөлбөр 2018 оны 83 дугаар тогтоолоор тус тус батлагдсан. | Хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилтын арга хэмжээнүүд хэрэгжиж, нэр төрөл нэмэгдсэн байна. | Төмс, ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтын түвшинг 20 хувьд хүргэж, Жимс, жимсгэний 50,0 мянгаас доошгүй суулгац нийлүүлэгдсэн байна. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ХХААГ |
| 13 | 13 | АИТХ-ийн Төлөөлөгчийн санал | Хүлэмжийн ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх | 2018 онд Шаамар суманд 10 хүлэмжийг худаг, хашааны хамт иж | Сумдад энэ арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцлийг | Богино болцтой хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэх нөхцөл | Аж ахуйн нэгжүүдийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ХХААГ, ААНБ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | замаар ажлын байр бий болгох | бүрнээр байгуулж, 20 хүнийг ажлын байраар хангах арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн. | бүрдүүлсэн байна. | бий болж, 50-иас доошгүй иргэн ажлын байраар хангагдсан байна. | | |
| 14 | 14 | АИТХ-ийн Төлөөлөгчийн санал | Авто зам дагуу ногооны борлуулалтыг дэмжих зорилгоор худалдааны цэгүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлэх | Баянгол суманд ногооны борлуулалтын худалдааны цэг бий болсон. | Авто замын дагуу ногоо худалдан борлуулах худалдааны цэгүүд бий болгосон байна. | Иргэдийн ногоогоо борлуулах нөхцөлөөр хангагдаж, өрхийн ашиг орлого нэмэгдэж амьжиргаа дээшилсэн байна. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг сумдын, ЗДТГ, ХХААГ |
| 15 | 15 | Эдийн засаг хөрөнгө оруулалтын чуулганаас гарсан санал | Төмс, хүнсний ногооны чиглэлээр өрхийн аж ахуй эрхэлдэг ногоочдын усалгааны асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх | Аймгийн дүнгээр 3.5 мянган га усалгаа бүхий талбай ашиглалтгүй байна. | Усалгаатай талбайг бүртгэлжүүлж, эзэмшилт, ашиглалтыг тогтмолжуулсан байна | Нэгж га-гаас авах ургацын хэмжээ нэмэгдсэн байна. | Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр | Аймаг сумдын, ЗДТГ, ХХААГ |
| 16 | 16 | АЗДҮАХ-ийн 1.2.8 | Сумдад ногооны зоорийг шинээр барьж байгуулж, ногооны хадгалалтыг нэмэгдүүлэх | Аймгийн дүнгээр төмс, хүнсний ногооны ургацын 46 хувийг хадгалах боломжтой. | Төмс хүнсний ногооны 2000 тн-ын багтаамжтай зоорь барих хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн байна. | Ногоочдын амьжиргааны түвшин дээшилсэн байна. | Улс, орон нутаг, төсөл хөтөлбөрийн байгууллагын хөрөнгөөр | Аймаг сумдын, ЗДТГ, ХХААГ |
| 17 | 17 | АИТХурлаас гарсан санал | Тариалангийн талбайд сүрлэн хучлага үүсгэх замаар хөрсний чийгийн нөөцийг бий болгох ажлыг эрчимжүүлэх | Тариалангийн нийт талбай сүрлэн хучлагыг хэрэглэж байна. | Тариалангийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд тариалангийн талбайн сүрлэн хучлагыг хийж хэвшсэн байна. | Нэгж га-гаас гарах ургацын хэмжээ нэмэгдсэн байна. | Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр | Аймаг сумдын, ЗДТГ, ХХААГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.2 Байгаль, орчны бодлого** | | | | | | | | |
| **Байгалийн унаган төрх, тэнцвэрт байдлыг хадгалж, зохистой ашиглах, нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэн, байгалийн нөөц баялгийг эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн үндэс болгоно.** | | | | | | | | |
| 18 | 1 | АЗДҮАХ-ийн 1.2.1 | Ойн нөөцийг хамгаалах, үр өгөөжтэй ашиглах, нөхөн сэргээх, мэргэжлийн байгууллагуудын менежментийг сайжруулах, ойн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, жил бүр 1500-аас доошгүй га талбайд ойжуулалт хийх | 2018 онд Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар-365 га, мод бэлтгэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын өөрийн хөрөнгөөр 800 га, Япон улсын төрийн бус байгууллагын хөрөнгө оруулалтаар 25 га тус тус гүйцэтгүүлж аймгийн хэмжээнд нийт 1190 га талбайд ойжуулалтын ажил хийгдсэн. | 2019 онд Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал, мод бэлтгэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын өөрийн хөрөнгө, аймгийн хэмжээнд нийт 1500 га талбайд ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгүүлнэ. | Ойн хөнөөлт шавжид нэрвэгдсэн, цөлжилтөд өртсөн талбайн хэмжээ багассан байна. | Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар | Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ, Сум дундын ойн анги, Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүд |
| 19 | 2 | АЗДҮАХ-ийн 1.2.1 | Сайн чанарын стандартын шаардлага хангасан модлог ургамлын үр худалдан авч үрийн нөөц бүрдүүлэх | Модлог ургамлын үрийн нөөц хангалтгүй | Үр түүх байнгын талбайгаас үр түүж бэлтгэнэ. | Сор шилэмэл модны сайн чанарын үрээр ойжуулалт нөхөн сэргээлт хийнэ | Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар | Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ |
| 20 | 3 | АЗДҮАХ-ийн 1.2.1 | Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх | 2018 онд гэрлэн урхи, өндөг түүх, үүргийн шүршигчээр 12000 га талбайд тэмцлийн ажил явуулсан. | Ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажлыг 15000 га талбайд явуулсан байна | Хөнөөлт шавжид нэрвэгдсэн талбайн хэмжээ багасан, тархалт буурч, модны тааварлаг чанар сайжирсан байна. | Байгаль орчин, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар | Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ, Сум дундын ойн анги болон мэргэжлийн байгууллагууд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | 4 | АЗДҮАХ-ийн 1.2.1 | Хүдэр, Ерөө, Мандал, Баруунбүрэн, Цагааннуур сумын ойн санд сибирь хуш, жодооны тарьц, суулгацаар ойжуулалт хийх | Сибирь хуш, жодооны тарьцаар 40 га талбайд ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. | Хүдэр, Ерөө, Мандал, Баруунбүрэн, Цагааннуур сумдад сибирь хуш, жодооны тарьц суулгацаар ойжуулна. | Уул уурхай болон хүний буруутай үйл ажиллагааны нөлөөгөөр устаж нөөц нь багасч буй хуш, жодоон ойн нөөцийг хамгаалж, үр ашиг бүхий ойн нөөц нэмэгдсэн байна. | Байгаль орчин, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар | БОАЖГ Ойн мэргэжлийн байгууллага, Ойн анги, |
| 22 | 5 | АЗДАҮХ-ийн 1.2.1 | Ойн нөхөрлөлүүдийн санхүүгийн чадавхийг бэхжүүлэх сургалт явуулж, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах | Ойн нөхөрлөлийн санхүүгийн чадавх, дадлага туршлага дутмаг байна. | Сургалт, үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан байна. | Ойн нөхөрлөлийн дундын сангийн хэмжээ нэмэгдэж, чадавхижсан байна. | Байгаль орчин, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар | БОАЖГ, Ой бүхий Сумдын ЗДТГ, Сумын болон сум дундын ойн ангиуд, |
| 23 | 6 | АЗДҮАХ-ийн 1.2.2 | Хог хаягдлыг устгах цэг болон хог хаягдал хадгалах түр цэгийн байршлыг тогтоон тохижуулах, хашаажуулах арга хэмжээг авч хог хаягдлын нэгдсэн мэдээллийн сантай болж, иргэдийн ухамсар, сэтгэлгээг дээшлүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах | Төвлөрсөн хогийн цэгүүд чанар стандартын шаардлага хангахгүй ил задгай хаягдаж байгаль орчныг их хэмжээгээр бохирдуулж байна. | Төвлөрсөн хогийн цэгийг хашаажуулж, камержуулсан байна. | Байгаль орчны бохирдолт багассан байна. | Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар | Аймаг, сумын ЗДТГ, БОАЖГ |
| 24 | 7 | АЗДҮАХ-ийн 1.2.2 | Мандал, Сайхан сумдын агаарын бохирдлыг тодорхойлох нарийвчилсан | Мандал сумын агаар дахь азотын давхар ислийн хэмжээ өнгөрсөн оныхоосоо 4,5,6,8 | Мандал,Сайхан сумдыг агаарын бохирдолын хэмжээ тодорхой болно | Агаарын чанарын үнэлгээг үндэслэн цаашид хийх | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, УЦУОШТ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэмжилт судалгааг хийж агаарын чанарын үнэлгээг тогтоох | дугаар саруудад эрс нэмэгдсэн. Агаар бохирдуулагч эх үүсвэр болох галлагаатай айл өрхийн тоо буурч байгаа боловч автомашины тоо жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд аймгийн нийт агаар бохирдуулагч эх үүсвэрийн 24 хувь нь Мандал суманд байна | | ажлаа төлөвлөх боломжтой болно. | | |
| 25 | 8 | АЗДҮАХ-ийн 1.2.2 | Сүхбаатар суманд хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэрийг байгуулж, хог хаягдал зайлуулах технологийг нэвтрүүлэх | Хог хаягдлын үйлдвэр байхгүй болно. | Хог хаягдлыг ангилан ялгаж эцсийн бүтээгдэхүүн бий болсон байна. | Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэр бий болсон байна. | Аймаг, сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ |
| 26 | 9 | АЗДҮАХ-ийн 1.2.3 | "Ногоон Сэлэнгэ" аян, хөдөлгөөнийг өрнүүлж, төв суурин газрын тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх | “Ногоон-Сэлэнгэ” хөдөлгөөний хүрээнд 1502 аж ахуйн нэгж, 38288 иргэн, 135200 ширхэг мод, бут, сөөг тарьж ургуулан хамгаалалтанд аваад байна. | Ногоон байгууламжийн талбайн хэмжээ 20 хувиар нэмэгдсэн байна. | Иргэдийн ая тухтай амьдрах орчин, нөхцөл бүрдэнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 27 | 10 | АЗДҮАХ-ийн 1.2.4 | Хөв цөөрөм байгуулах боломжит газрын судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх | Одоогийн байдлаар хөв цөөрөм байгуулах газруудын судалгаа байхгүй. | Хөв цөөрөм байгуулах боломжтой газруудын судалгаа гарсан байна. | Шар усны үер болон хур борооны усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулах боломжит газрын судалгаатай болно. | Байгаль орчин, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар | БОАЖГ, ХХААГ, Мэргэжлийн байгууллага |
| 28 | 11 | АЗДҮАХ-ийн 1.2.4 | Сумдад булаг, шандны эхийг хамгаалж ундаргыг сэргээх арга хэмжээг авах | “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал”-аар 5 булгийн эхийг тохижуулсан. | Сумдын судалгааг үндэслэн 5 булгийн эхийг хашаажуулна. | Булаг шанд хамгаалагдан усны ундарга сайжирна. | Байгаль орчин, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар | Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ |
| 29 | 12 | АЗДАҮХ-ийн 1.2.4 | Ерөө голын усны чанар, нөөцөд хяналт тавих ус судлалын харуул Бугант тосгонд шинээр байгуулж ажиллуулах | Алт олборлож буй хууль бус иргэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас Бугант, Ерөө голууд бохирдож Ерөө голын усны нөөц 2017 онд уур амьсгалын дунджаас 0.87 $км^3$-ээр бага байсан. Бугант голруу цутгадаг Сангийн, Дунд, Бага, Өлөнт, Толгойтын зэрэг жижиг голууд тасарч ширгэсэн байна. | Ерөө Бугант голын усны чанар нөөцөд хяналт тавих боломж бүрдэнэ | Ерөө, Бугант голын усны чанар нөөцөд хяналт тавих боломж бүрдэнэ | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | УЦУОШТ, Тосгоны Захирагчийн алба |
| 30 | 13 | АЗДҮАХ-ийн 1.2.5 | Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах бодлого хэрэгжүүлж, уул уурхайн хайгуул, олборлолтод | Уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж эвдрэлд орсон 3768 га газар тоологдсон. | Уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээнэ. | Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулж, эвдрэлд орсон газар нутгийг | Аж ахуйн нэгжүүдийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ, ХХААГ, ААНБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээх | | | нөхөн сэргээнэ. | | |
| 31 | 14 | АЗДҮАХ-ийн 1.2.6 | Сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Түгээмэл тархацтай ашигт малтмал болон уул уурхайн ашиглалт, хайгуулын зориулалттай газрын ашиглалтыг тусгаж баталгаажуулах | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн талбай сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд огт тусгагдаагүй байна. | Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалт, хайгуулын зориулалттай тусгай зөвшөөрөл бүхий газрыг аймгийн нэгдсэн кадастрын мэдээллийн санд бүртгэх ажил тогтмолжсон байна. | Газрыг давхардуулан олгохгүй байх нөхцөл бүрдэнэ. | - | Аймаг, сумдын ЗДТГ, ГХБХБГ |
| 32 | 15 | АЗДҮАХ-ийн 1.2.7 | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 151-р тогтоолоор батлагдсан журмыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллах | Аймгийн хэмжээнд журмын дагуу бүртгэлжсэн 14 нөхөрлөл бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байна. | “Бичил уурхай эрхлэгчдийн талаар баримтлах” чиглэлийн хэрэгжилтийг ханган ажиллана. | Бичил уурхай эрхлэгчдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, тэдэнд үзүүлэх нийгмийн суурь үйлчилгээ сайжирсан байна. | Төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, МХГ, БОАЖГ |
| 33 | 16 | АЗДҮАХ-ийн 1.2.8 | Аймгийн хэмжээнд ерөнхий агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежмент төлөвлөгөөг боловсруулах ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх | Сэлэнгэ аймгийн ан агнуурын менежмент төлөвлөгөөний /2014-2018/ хугацаа дууссан. | Сэлэнгэ аймгийн ан агнуурын менежмент /2019-2023/ төлөвлөгөөтэй болсон байна. | Ан агнуурын менежмент төлөвлөгөөтэй болсноор ахуйн болон тусгай зориулалтаар агнах барих агнуурын амьтны тоо,толгой тодорхой болно. | Байгаль орчин, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар | Мэргэжлийн байгууллага, БОАЖГ |
| 34 | 17 | АЗДҮАХ-ийн 1.2.9 | Баруунбүрэн, Мандал, Түшиг, Цагааннуур, Хүдэр сумдад ховор | 2017-2018 онд Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга | Ховор, нэн ховор ургамлын судалгаа, тархац, нөөц, зураглал, тооллого | Зарим ургамлын хамгаалалтад авах шаардлага, нөхөн сэргээлт | Байгаль орчин, нөхөн сэргээх арга хэмжээний | Мэргэжлийн байгууллага, |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | болон нэн ховор ургамлын нөөц, тархалтын нарийвчилсан судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх | хэмжээний зардлаар “Байгалийн ургамлын аймгийн тооллого, зураглалыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх ажил”-ыг тусгаж оруулан “Экотайкүүн” ХХК-аар гүйцэтгүүлсэн. | зэргийн иж бүрэн судалгаа, материал, мэдээллийн сантай болно. | хийх газар тодорхойлогдоно . | зардлаар | Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ |
| 35 | 18 | АЗДҮАХ-ийн 1.2.9 | Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлийг хамгаалах, ховордсон ургамлыг тарималжуулах, үржүүлэх санал санаачилгыг дэмжих | Байгалийн ургамлыг тарималжуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулах хүсэлтэй 1 аж ахуйн нэгжид арга зүйн зөвлөгөө өгсөн | Үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгжүүдэд сургалт зохион байгуулж байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | Ховор, нэн ховор ургамлын тоо хэмжээ нэмэгдсэн байна. | Иргэн, аж ахуйн нэгжүүдийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ, ААНБ |
| 36 | 19 | АЗДҮАХ-ийн 1.2.10 | Уул уурхайн зориулалтаар ашиглаж байгаа газрын мэдээллийн санг бүрдүүлэх, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж газрыг улсын бүртгэлд бүрэн хамруулах | Сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу Ерөө суманд 6, Орхонтуул суманд 1, Сайхан суманд 20, Түшиг суманд 3, Баянгол суманд 7, Мандал суманд 9 аж ахуйн нэгж буюу аймгийн хэмжээнд нийт талбайд газар | Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл бүхий нийт 84 талбайг газрын бүртгэлд хамруулсан байна. | Кадастрын мэдээллийн санд нөхөн бүрдүүлэлт хийж аймгийн газрын төлбөрийн орлого нэмэгдэнэ. | - | ГХБХБГ, |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эзэмших, ашиглах гэрээ байгуулж, газрын улсын бүртгэлд хамруулснаар газрын төлбөрийн орлого 45.046.92 төгрөгөөр нэмэгдсэн. | | | | |
| 37 | 20 | АЗДАҮХ-ийн 1.2.10 | Газар өмчлөхтэй холбогдсон хууль тогтоомжийг сурталчлан газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлэх | Иргэдийн 39 хувь нь газраа албан ёсоор өмчилж авсан байна. | Газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлж 43 хувьд хүргэнэ. | Газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөл боломж бүрдсэн байна. | - | Аймаг, сумдын ЗДТГ, ГХБХБГ |
| 38 | 21 | АЗДҮАХ-ийн 1.2.11 | Аймгийн нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгож, мэдээллийг нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх | Солбицолын нэгдсэн тогтолцоонд шилжсэн 1:1000 машстабтай байр зүйн зураг хийгдэн мэдээллийн санд баяжилтыг тухай бүр хийж байна. | Аймгийн нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулж геодезийн нэгдсэн сүлжээг бий болно | Аймгийн нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулсан байна. | - | ГХБХБГ, Сумдын ЗДТГ |
| 39 | 22 | АЗДҮАХ-ийн 1.2.12 | Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг нийтэд ил тод цахим хэлбэрээр явуулах | Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг цахимаар явуулдаггүй. | Иргэдэд мэдээ мэдээллийг тухай бүр авах боломжийг бүрдүүлж дуудлага худалдааг цахимаар зохион байгуулах үйл ажиллагаа тогтмолжсон байна. | Иргэдийн санал, өргөдөл, гомдол багассан байна. | - | Аймаг, сумдын ЗДТГ, ГХБХБГ |
| 40 | 23 | АЗДҮАХ-ийн 1.2.13 | Алтанбулаг, Хүдэр, Хушаат, Ерөө, Мандал сумдад рашаан төст булгуудын судалгааг | Рашаан төст булгийн судалгаа байхгүй | Дээрх сумдад буй рашаан төст булгийн судалгаатай болно. | Дээрх сумдад байгаа рашаан төст булгуудын найрлага, эрүүл мэндийн үйлчилгээ | Байгаль орчин, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар | Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ, Геоэкологийн хүрээлэнгийн усны сектор |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх | | | тодорхой болж, түүнийг даган НИТАЖ хөгжих боломж бий болно. | | |
| 41 | 24 | АЗДАҮХ-ийн 1.2.13 | Жавхлант сумын Ерөө голын Ногоон тохойд “Жавхлант эко тур” жуулчны бааз байгуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх | “Жавхлант эко тур” нь 110 хүний багтаамжтай гэр, байшин, өвлийн байшин байгуулахаар зураг төсөв хийгдэн барилга байгууламжийн явц 60 хувьтай байна. | “Жавхлант эко тур” жуулчны бааз ашиглалтанд орсон байна. | Сэлэнгэ аймагт аялах жуулчдын тоо нэмэгдэж, эдийн засгийн үр өгөөж нэмэгдсэн байна. | Аж ахуйн нэгжийн хөрөнгөөр | АЗДТГ, БОАЖГ, ГХБХБГ |
| 42 | 25 | АИТХурлаас гарсан санал | Амралт, аялал жуулчлалын газруудыг стандарт шаардлагад нийцүүлэн, хамтарч ажиллах | Баруунбүрэн, Алтанбулаг, Шаамар сумдын зарим амралтын газрууд орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн био 00 ашиглаж байна. Мөн ГОУХАН-ийн ЭТИС хөтөлбөрийн хүрээнд АЗДТГ, болон төсөл хэрэгжүүлэгч “Хөвчит нум” нөхөрлөлд нийт 3-н био 00 олгогдсон. | Аялагч жуулчид өргөнөөр ирдэг байгалийн үзэсгэлэнт газар, түүх дурсгалын газар, амралтын газрууд орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн био 00 ашигладаг болсон байна. | Стандартын хэрэгжилт сайжирч, аялагч жуулчдын сэтгэл ханамж нэмэгдэнэ. | Төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ |
| 43 | 26 | АЗДҮАХ-ийн 1.2.17 | "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тооцох | "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги төлөвлөгөө" боловсруулж байна. | "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги төлөвлөгөө" боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллана. | Байгальд халтай сөрөг нөлөөлөл багассан байна. | Байгаль орчин, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар | Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ, УЦУОШТ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 44 | 27 | - | Цаг агаарт зориудаар нөлөөлж мөндөр зайлуулах үйл ажиллагааг судалж, турших ажлыг эхлүүлэх | Цаг агаар зориудаар нөлөөлөх 4 экспедицууд 2018 оны 4-р сарын 27-ноос эхлэн цаг агаарт зориудаар нөлөөлөх нөхцөл бүрдсэн 18 тохиолдолд 68 удаа хээрийн үйл ажиллагаа явуулж 132 ширхэг пуужин харваж, ажилласан. | Орох хур тунадасны хэмжээг нэмэгдүүлнэ. | Таримал болон бэлчээрийн ургац нэмэгдэнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | АЗДТГ, УЦУОШТ |
| 45 | 28 | АЗДАҮХ-ийн 1.2.18 | Цөлжилтийн судалгааг эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлж, Цөлжилттэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллага, нөхөрлөл, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих | Цөлжилтийн судалгааг нийт 72 цэгт хийсэн бөгөөд "Цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийг эрчимжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г батлуулсан. | Цөлжилт, элсний нүүлт ихээр явагдсан газрыг сум бүрээр гаргасан байна. ТББ нөхөрлөлтэй хамтран цөлжилттэй тэмцэх чиглэлээр тодорхой арга хэмжээг авч ажилласан байна. | Цөлжилтийн хэмжээ багассан байна. | Байгаль орчин, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар | Геоэкологийн хүрээлэн, УЦУОШГ, БОАЖГ |
| **1.3 Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний бодлого** | | | | | | | |
| **Сум бүр үйлдвэрлэгч байж, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 46 | 1 | АЗДҮАХ-ийн 1.3.1 | "Сум бүрт нэг үйлдвэр үйлчилгээ хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулж үр дүнг тооцох | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан. | Сум бүрт үйлдвэр үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн байна. | Ажлын байр нэмэгдэж, иргэдийн амьжиргааны түвшин дээшилсэн байна. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 47 | 2 | АЗДҮАХ-ийн 1.3.2 | “Сэлэнгэд үйлдвэрлэв”, "Сэлэнгийн ургац-2019”, “Бумбаны баяр” арга хэмжээг зохион байгуулж, иргэдийн ашиг орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх | “Сэлэнгэд үйлдвэрлэв” “Сэлэнгийн ногоон өдрүүд” арга хэмжээнд 17 сумын 400 аж ахуйн нэгж, иргэдийн 300 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 67.5 сая төгрөгийн борлуулалт хийсэн. | Аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулан борлуулалтын орлогыг нэмэгдүүлсэн байна. | Үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээл, хэрэглэгчдэд таниулж, иргэдийн ашиг орлого нэмэгдсэн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ХХААГ |
| 48 | 3 | АЗДҮАХ-ийн 1.3.2 | Зарим сумдад төмс, хүнсний ногоо угааж савлах жижиг үйлдвэр, цехийгбий болгох иргэд, аж ахуйн нэгжийн санал санаачлагыг дэмжих | Баянгол суманд төмс, хүнсний ногоо угааж савлах үйлдвэртэй. | Төмс, хүнсний ногоог угааж савлах, жижиг, үйлдвэр, цехийг техник тоног төхөөрөмжөөр хангаж, үйл ажиллагааг эхлүүлсэн байна | Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн бий болж, иргэдийн ашиг орлого нэмэгдэж, амьжиргаа дээшилсэн байна. | Орон нутгийн төсвийн болон аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ХХААГ |
| 49 | 4 | - | Байгалийн гаралтай жимс жимсгэнэ боловсруулах жижиг үйлдвэр цехийг Хүдэр, Түшиг суманд байгуулах | Жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэрийг байгуулах талаар хүнсний үйлдвэрүүдтэй санал солилцож байна. | Анхан шатны үйлдвэр цех бий болсон байна. | Ажлын байр нэмэгдэж иргэдийн амьжиргаа дээшилсэн байна. | Орон нутгийн төсвийн болон аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ХХААГ |
| 50 | 5 | АЗДҮАХ-ийн 1.3.2 | Зарим сумдад хуванцар, хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах | Аймгийн ИТХТ-ийн 2018 оны 85 дугаар тогтоолоор “Сум бүрт нэг үйлдвэр үйлчилгээ хөтөлбөр” батлагдсан. | Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулах үйлдвэр байгуулсан байна. | Байгаль орчны бохирдол багасч, ажлын байр нэмэгдэж иргэдийн амьжиргаа дээшилсэн байна. | Орон нутгийн төсвийн болон аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ХХААГ |
| 51 | 6 | АЗДҮАХ-ийн 1.3.5 | Аймгийн онцлогийг харуулсан сувинер, бэлэг дурсгалын | “Үзэсгэлэнт Сэлэнгэ” гар урлал, бэлэг дурсгалын | Нум сум болон гар урлал, аймгийн үзэсгэлэнт ба түүх | Сүхбаатар суманд аймгийн онцлогийг | Төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, GIZ төсөл |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж ахуйн нэгж, иргэдийг дэмжих | бүтээлийн уралдааныг зохион байгуулж, 6.6 сая төгрөгийн зарцуулсан байна. | соёлын дурсгалт газруудын зургийг фото болон уран зураг хэлбэрээр хийж худалдаанд гаргана. | харуулсан сувинер, бэлэг дурсгалын бүтэгдээхүүнийг борлуулдаг нэрийн дэлгүүртэй болсон байна. | | |
| 52 | 7 | АЗДҮАХ-ийн 1.3.6 | Арьс, шир, ноос, ноолууранд анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр, цехийг тооцоо судалгаа, түүхийн эдийн нөөцийг үндэслэн төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор зарим сумдад байгуулах | Аймгийн хэмжээнд арьс, шир, ноос, ноолуур эсгийн анхан шатны боловсруулах “Шилмэл эсгий” “Зүүнхараа кашмер”-ын үйлдвэр ажиллаж байна. | Анхан шатны боловсруулах үйлдвэр цехийн тоог нэмэгдүүлсэн байна. | Ажлын байр бий болж, иргэдийн ашиг орлого нэмэгдэнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ХХААГ |
| 53 | 8 | АЗДҮАХ-ийн 1.3.8 | Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжин импортыг орлох экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих | Аймаг орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээ бага байдаг. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авахад дотоодын бүтээгдэхүүнээс тодорхой хувийг авч хэвшүүлсэн байна. | Тухайн орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг хэрэглэх, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авахад дотоодын бүтээгдэхүүнээс авах хэвшүүлсэн байна. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ХХААГ |
| 54 | 9 | АЗДҮАХ-ийн 1.3.9 | Сүхбаатар, Мандал, Сайхан суманд “Гялгар уутнаас таталзах | Худалдаа, үйлчилгээний байгууллагууд стандартын | Өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулсан байна. | Иргэд хэрэглээний зөв хэвшилтэй болж, хүнсний аюулгүй | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ХХААГ, СХЗХ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | өдөрлөг”-ийг зохион байгуулж, байгальорчин, хүнийэрүүлмэндэд сөргөөр нөлөөлж буй хор уршигийг таниулан сурталчлах | шаардлагад нийцэхгүй гялгар уутаар үйлчилж байна. | | байдал сайжирсан байна. | | |
| 55 | 10 | ИТХ-ын санал | Шаамар суманд зөгийн бал, зөгийн бүтээгдэхүүн савлах цех байгуулах | Туркийн хамтын ажиллагааны ТИКА төслөөр 1000 бүл зөгий өвөлжүүлэх, зөгийн зоорь ашиглалтанд оруулсан. | Шаамар суманд зөгийн бал, зөгийн бүтээгдэхүүн савлах үйлдвэр байгуулсан байна. | Ажлын байр нэмэгдэж, иргэдийн орлого нэмэгдсэн байна. | Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ХХААГ |
| 56 | 11 | - | Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийг сайжруулж, үр дүнг тооцож ажиллах | Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлт 72 хувьтай байна. | Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг 85 хувьд хүргэнэ | Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлт сайжирч, иргэд аж ахуйн нэгжид олгох зээлийн хэмжээ нэмэгдсэн байна. | - | Аймаг сумдын ЗДТГ, ХХААГ |
| **1.4 Хөрөнгө оруулалт, дэд бүтцийн бодлого, шинэчлэлийн хүрээнд** | | | | | | | | |
| **Хүн амыг эрүүл орчинд, ая тухтай амьдрах нөхцлийг тогтвортой сайжруулна** | | | | | | | | |
| 57 | 1 | АЗДҮАХ-ийн 1.4.1 | Зарим сумдын газар зохион байгуулалтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгэх | Жавхлант, Зүүнбүрэн, Хүдэр сумдын хот, төлөвлөлт, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгавар батлагдсан. | Жавхлант, Зүүнбүрэн, Хүдэр сумдын хот, төлөвлөлт, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгэж аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан байна. | Хот төлөвлөлт газар зохион байгуулалтын оновчтой төлөвлөлт бий болж сумд орчин үеийн жишгээр хөгжих нөхцөл боломж бүрдсэн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ГХБХБГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 58 | 2 | АЗДҮАХ-ийн 1.4.2 | Онцгой нөхцөлд ажилладаг төрийн албан хаагчдын, нийгмийн баталгааг хангаж орон сууцжуулах, орон сууц барих талаар санал санаачлага гаргасан иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих | Аймгийн хэмжээний нийт өрхийн 80 гаруй хувь нь гэр хороололд ердийн галлагаа буюу зуух, ханан пийшингээр халаалтынхаа асуудлыг шийдвэрлэн амьдарч байна. | Сүхбаатар суманд нийтийн орон сууцны 150 айл, амины орон сууцны 10 айл, Орхон суманд төрийн албан хаагчдын 4 айлын орон сууц тус тус ашиглалтад орсон байна. | Иргэд, төрийн албан хаагчдын ая тухтай орчин нөхцөлд амьдрах боломж бүрдсэн байна. | Орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөр, аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ГХБХБГ |
| 59 | 3 | АЗДҮАХ-ийн 1.4.2 | Сүхбаатар сумын ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгыг дахин төлөвлөх шинээр орон сууц барих ажлыг эхлүүлэх | Сүхбаатар суманд ашиглалтын шаардлага хангахгүй талаар Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техникийн улсын байцаагчийн дүгнэлт гарсан 7 орон сууц байна. | Сүхбаатар сумын төв хэсэгт байрлах 21, 22, 23, 25 дугаар байрыг дахин төлөвлөлтөд хамруулах талаар нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, хэрэгжүүлж эхэлсэн байна. | Иргэдийн аюулгүй орчин амьдрах нөхцөл боломж хангагдана. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ |
| 60 | 4 | АЗДҮАХ-ийн 1.4.2 | Сүхбаатар сумын Орхоны 6 дугаар багийн нийтийн орон сууцны байруудын подвалийн инженерийн шугам сүлжээнд засвар шинэчлэлт хийх | 2018 онд Сүхбаатар сумын 2 дугаар багийн нийтийн орон сууцны байруудын подвалийн инженерийн шугам сүлжээнд засвар хийсэн. | Шар таван давхарын 1-13 дугаар байруудын подвалийн инженерийн шугам сүлжээг засварласан байна. | Оршин суугчдын ая тухтай амьдрах орчин нөхцөл бүрдсэн байна. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ |
| 61 | 5 | АЗДҮАХ-ийн 1.4.5 | Зарим сумдын цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчилж, шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийн | Сумдын цахилгаан дамжуулах агаарын шугамын 80 хувь нь 35-55 жилийн насжилттай, айл өрхүүд хүчдэлийн | Зарим сумдын цахилгаан дамжуулах агаарын шугамыг төмөр бетон тулгуур, СИП кабелиар шинэчилж, | Найдвартай эрчим хүчээр хангагдана. Өмчилж авсан газартаа амьдрах нөхцөл боломж бүрдсэн | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, “Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ХК |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | асуудлыг шийдвэрлэх | уналттай байна. Мөн Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар суманд шинэ суурьшлын бүсэд газар олгосон. | өргөтгөн, ухаалаг тоолуур төвлөрүүлсэн байна. | байна. | | |
| 62 | 6 | АЗДҮАХ-ийн 1.4.5 | “Эрчим хүч хэмнэх хөтөлбөр” боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулах | 2015 онд Эрчим хүч хэмнэх тухай хууль батлагдсан. | Эрчим хүч хэмнэх хөтөлбөрийг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаан ажилласан байна. | Эрчим хүчний хэмнэлт бий болж эдийн засгийн үр өгөөж бий болсон байна. | Төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ГХБХБГ, Эрчим хүчний зохицуулах зөвлөл |
| 63 | 7 | АЗДҮАХ-ийн 1.4.6 | Жавхлант, Орхон сумдыг төвлөрсөн дулаан хангажийн системд холбож, Түшиг сум, Номгон тосгоны халаалтын төвд тогооны шинэчлэл хийх | Жавхлант, Орхон сумдын төвлөрсөн дулаан хангамжийн ажлыг эхлүүлсэн. Түшиг сум, Номгон тосгоны зуух хуучирч, хүчин чадлаараа ажилладаггүй. Төр төсвийн байгууллагуудын халаалт стандартын хэмжээнд хүрдэггүй. | Шинээр зуух суурьлуулсан байна. | Төр, төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн ая тухтай амьдрах орчин нөхцөл бүрдсэн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, ГХБХБГ |
| 64 | 8 | АЗДҮАХ-ийн 1.4.7 | “Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ-т машин механизмын парк шинэчлэлт хийх | Салбар шугам сүлжээний 80 хувь нь 20-25 жилийн насжилттай болсон. Өвлийн улиралд шугам сүлжээ цоорох эрсдэл их гарах болсон. Одоогоор ашиглалтын хугацаа дууссан | Парк шинэчлэлт хийсэн байна. | Өвлийн улиралд эвдрэл гэмтэл гарсан үед түргэн шуурхай засварлаж, иргэдийг аюулгүй орчинд ая тухтай амьдрах нөхцөл боломжийг хангасан байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, “Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ковш ажиллаж байна. | | | | |
| 65 | 9 | АЗДҮАХ-ийн 1.4.8 | Зарим сумдад цэвэрлэх байгууламж барьж, сумдын усан сан, ус хангамжийн шугам сүлжээнд засвар шинэчлэлт хийх | Ерөө сумын Бугант тосгоны цэвэрлэх байгууламж барих ажлын зураг төсөв хийгдсэн. | Зарим сумдад цэвэрлэх байгууламж барьж, сумдын усан сан, ус хангамжийн шугам сүлжээнд засвар шинэчлэлт хийсэн байна. | Ая тухтай орчинд амьдрах нөхцөл бүрдсэн байна. | Улсын төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ГХБХБГ, “Урсгал-Ус” ХХК |
| 66 | 10 | АЗДҮАХ-ийн 1.3.8 | Аймгийн хэмжээнд барилгын материалын үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийг тохирлын гэрчилгээтэй болгох | Тохирлын гэрчилгээгүй зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явагдаж байна. | Тохирлын гэрчилгээтэй болсон байна. | Барилгын материалын чанар дээшилж аж ахуйн нэгж байгууллагуудын борлуулалтын орлого өссөн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | ГХБХБГ |
| 67 | 11 | АЗДҮАХ-ийн 1.4.9 | Шаардлагатай сумдад гүний худаг гаргаж, зарим сумдын ус түгээгүүрийн худгийг ухаалаг системд шилжүүлэх | Бэлчээрийн ус хангамжийн хүртээмж муу, усыг холоос зөөдөг, 2017, 2018 онд Сүхбаатар сумын 9 худгийг ухаалаг системд шилжүүлсэн нь үр дүнтэй ажил болсон. | 2-3 гүний худаг барьж, 4-5 худгийг ухаалаг системд шилжүүлсэн байна. | Ус хангамжийн хүртээмж сайжирсан байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ |
| 68 | 12 | АЗДҮАХ-ийн 1.4.10 | Сүхбаатар сумын төв зам дагуу ус зайлуулах систем, шинээр баригдсан замуудад явган хүний зам барих | 2018 онд төв зам дагуух бродюрыг солисон | Ус зайлуулах систем болон явган хүний зам барих | Замын ашиглалтын хугацаа уртсаж, иргэдийн аюулгүй орчинд зорчих нөхцөл боломж бүрдсэн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ГХБХБГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 69 | 13 | АЗДҮАХ-ийн 1.4.10 | Сүхбаатар сумын ногоон байгууламжид усалгааны систем хийх | Ногоон байгууламжуудыг автомашинаар зөөвөрлөн өртөг зардал ихтэйгээр усалж байна. | Усалгааны систем суурьлуулсан байна. | Ногоон байгууламж жигд урган хотын өнгө үзэмж нэмэгдсэн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ГХБХБГ, БОАЖГ |
| 70 | 14 | АЗДҮАХ-ийн 1.4.11 | Зарим сумдын төв, ачаалал ихтэй замуудыг хатуу хучилттай болгож, хурд сааруулагч, тэмдэг тэмдэглэгээ, зам засварын ажлыг тогтмол хийх | Хайрган замууд эвдрэл гэмтэл их, тээврийн хэрэгсэл зорчиход хүндрэлтэй байна. | 2019 оны улсын төсөв, аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтанд тусгагдсан хөрөнгөөр хатуу хучилттай авто зам тавьж, хурд сааруулагч, тэмдэг тэмдэглэгээ, зам засварын ажлыг хийнэ. | Иргэдийн аятай тухтай зорчих нөхцөл бүрдэж, зам тээврийн осол буурна. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ГХБХБГ, “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ |
| 71 | 15 | АЗДҮАХ-ийн 1.4.11 | Сүхбаатар сумын 1 дүгээр багаас “Сайханы хөтөл” хүртэлх 5.6 км хатуу хучилттай авто зам барих | Зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж магадлалаар батлуулсан. | 5.6 км авто замын барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна. | Эдийн засгийн болоод цаг хугацааны хэмнэлт бий болно. | Улсын төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ГХБХБГ |
| 72 | 16 | АЗДҮАХ-ийн 1.4.12 | Зарим сумдын үерийн хамгаалалтын далан, гүүрэнд засвар шинэчлэлт хийж, төмөр замтай огтлолцсон нүхэн гарц гаргах | Үерийн хамгаалалтын далан, ус зайлуулах сувагүйгээс болж айл өрх, албан байгууллагууд үерийн усанд автах, зам талбай үерийн усанд угаагдаж эвдрэл үүсч байна. | Үерийн далан, ус зайлуулах сувгийн зураг төсөлтэй болсон байна. | Байгалийн давагдашгүй хүчин зүйл болох үерийн усны гамшгийн эрсдэл буурсан байна. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг сумдын ЗДТГ, ГХБХБГ |
| 73 | 17 | | Сүхбаатар сумын төвийн шилэн кабелийн | Шилэн кабелийн сүлжээнүүд агаараар эмх | Сүхбаатар сумын төмөр замын 8 дугаар худгаас | Хотын өнгө үзэмж сайжирсан байна. | Улсын болон орон нутгийн төсвийн | Аймгийн ЗДТГ “МХС” ТӨХХК-ий |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сүлжээнүүдийг худаг сувагчлалд оруулах | замбараагүй татагдсан, хотын өнгө үзэмжид сөргөөр нөлөөлж байна. | Жаст ойлын 20 дугаар худаг, Холбооны байрнаас Спортын ордон, Төрийн банкнаас Нутгийн захиргааны 3 дугаар байр, Жаст ойлын 20 дугаар худгаас Олон улсын худалдааны тав, 12 дугаар дэлгүүрээс гурлын байр хүртэл тус тус худаг сувагчлал хийж агаараар татсан шугамыг цэгцлэнэ. | | хөрөнгөөр | Сэлэнгэ аймгийн газар |
| 74 | 18 | АЗДҮАХ-ийн 1.4.14 | “Манай гудамж-Миний гэр” хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллах | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 31 дүгээр тогтоолоор “Манай гудамж-Миний гэр” хөтөлбөрийг батлуулан, “Цэвэр орчин-Эрүүл амьдрал” аяныг өрнүүлэн ажилласан. | Сумдын гудамж талбай, айл өрхийг хаягжуулан, хашааг нэгдсэн нэг загвартай болгосон байна. | Иргэдийн ажиллаж амьдрах тав тухтай орчин бий болсон байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ГХБХБГ |
| 75 | 19 | АЗДҮАХ-ийн 1.4.14 | Сүхбаатар сумын нийтийн орон сууц, албан байгууллага, телевизийн цамхаг зэрэгт гэрлэн чимэглэл хийх | 2018 онд АЗДТГ, Сүхбаатар сумын ЗДТГ-ын барилга, төв талбайн цэцэрлэгт гэрлэн чимэглэл хийсэн | Сүхбаатар сумын нийтийн орон сууц, албан байгууллага, теливизийн цамхаг зэрэгт гэрлэн чимэглэл хийсэн байна. | Хотын өнгө үзэмж нэмэгдсэн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн АЗДТГ |
| 76 | 20 | АЗДҮАХ-ийн 1.4.14 | Сүхбаатар сумын 2 дугаар багийн 15-18 дугаар | Газрын асуудлыг шийдвэрлэж хашаажуулсан. | Тоглоомын болон амралт, зугаалгын талбайг байгуулсан | Иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, ГХБХБГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байрнуудын гадна тоглоом, 19, 20 дугаар байрны гадна иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх амралт, зугаалгын талбай байгуулах | | байна. | өнгөрүүлэх нөхцөл боломж бүрдсэн байна. | | |
| 77 | 21 | АЗДҮАХ-ийн 1.4.14 | Сүхбаатар сумын 8 дугаар багт байрлах хөл бөмбөгийн талбайг түшиглэн амралт зугаалгын төв байгуулах | Гадна хашааны ажил хийгдсэн | Дугуйн болон явган зам, тохижилтын ажлууд хийгдсэн байна. | Иргэдийн чөлөөт цагийг өнгөрүүлэх төв нээгдсэн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг сумын ЗДТГ, ГХБХБГ |
| 78 | 22 | АЗДҮАХ-ийн 1.4.14 | "Цагаан-Эрэг" болон "Гэрэлт", "Соёмбот" цогцолборыг гэрэлт гудамж болгон тохижуулах | Гэрэл хангалтгүй байна. | "Цагаан-Эрэг болон "Гэрэлт", "Соёмбот" цогцолборыг гэрлэн чимэглэлээр тохижуулсан байна. | Иргэд тав тухтай орчинд чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцөл боломж бүрдсэн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг сумын ЗДТГ, "Сэлэнгэ үйлчилгээ" ОНӨААТҮГ |
| 79 | 23 | АЗДҮАХ-ийн 1.2.13 | "Сайханы хөтөл"-д шилэн гүүр бүхий жишиг аялал жуулчлалын бүс байгуулах | Авто зогсоол, шилэн гүүр, хашаа, тохижилтийн ажлын зураг төсвийг хийж байна. | Зогсоол, шилэн гүүр, хашааг барьж тохижилтийн ажил хийгдсэн байна. | Аялал жуулчлал, амралт зугаалгын таатай орчин бий болсон байна. | Орон нутгийн төсвийн болон хувийн хэвшил гадаад дотоодын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, ГХБХБГ, ОНӨГ |
| 80 | 24 | АЗДҮАХ-ийн 1.2.13 | Сүхбаатар сумын 5 дугаар багт амралт зугаалга, хүүхэд залуучуудын тоглоомын парк бүхий цэцэрлэгт хүрээлэн барих ажлыг эхлүүлэх | Сүхбаатар сумын хогийн цэгийг түрж булшлах, амралт зугаалгын төв болгох зураг төсвийг хийж байна. | 5 дугаар багийн амралт зугаалга, хүүхэд залуучуудын тоглоомын парк бүхий цэцэрлэгт хүрээлэнгийн зам, зогсоол, хашаа, доторх явган хүний болон дугуйн замыг | Аялагч, жуулчлагчдын тоо нэмэгдсэн байна. | Орон нутгийн төсвийн болон хувийн хэвшил гадаад дотоодын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, ГХБХБГ, ОНӨГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | барьсан байна. | | | |
| 81 | 25 | АЗДҮАХ-ийн 1.4.16 | Сүхбаатар-Алтанбулагийн чиглэлийн замд Олон Улсын стандартад нийцсэн үйлчилгээ бүхий авто буудлын цогцолбор барих ажлыг эхлүүлэх | Авто буудал, цогцолборын газрын асуудлыг 2018 онд шийдвэрлэсэн. | Зоогийн газар, буудал, эко бие засах газар, авто засвар зэрэг үйлчилгээний барилгуудыг барьсан байна. | Иргэдийн аюулгүй зорчих нөхцөл боломж бүрдсэн байна. | Аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, ГХБХБГ |
| 82 | 26 | АЗДҮАХ-ийн 1.3.8, 2.4.10, 3.1.4 | Сүхбаатар сумын хуримын ордон, Орхонтуул сумын захирагчийн алба, соёлын төв, Ерөө сумын ахуйн үйлчилгээний төв, Сайхан сумын инженерийн шугам сүлжээ зэрэг ажлуудыг ашиглалтад оруулах | Барилга угсралтын ажлууд 30-70 хувьтай явагдаж байна. | Хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж ашиглалтад оруулсан байна. | Төрийн үйлчилгээ болон иргэдийн ахуй амьдрал дээшилсэн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, ГХБХБГ |
| 83 | 27 | Ажлын хэсгийн санал | “Сэлэнгэ аймгийн Тогтвортой хөгжлийн зорилт-2030” дунд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллах | 2018 онд бодлогын баримт бичгийн боловсруулалтын явцыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлсэн. Мөн олон нийтээс санал авах ажлууд хийгдсэн. | Дунд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжилтийг эхлүүлсэн байна. | Тогтвортой хөгжлийн үндэс суурь тавигдсан байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, Ажлын хэсэг |
| 84 | 28 | АЗДҮАХ-ийн 2.3.10 | Шаамар суманд “Морин спорт, аялал жуулчлалын | 2018 онд газрын асуудлыг шийдвэрлэсэн. | “Морин спорт, аялал жуулчлалын төв”-ийг байгуулах | Морин спорт хөгжих нөхцөл бүрдсэн байна. | Орон нутгийн болон төсөл, хөтөлбөрийн | Аймаг, сумын ЗДТГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төв"-ийг байгуулах ажлыг эхлүүлэх | | ажлыг эхлүүлсэн байна. | | хөрөнгөөр | |
| 85 | 29 | АЗДҮАХ-ийн 1.2.13 | Аймгийн төв Сүхбаатар суманд Буурын голыг түшиглэн Усан парк болон мөсөн цогцолбор барих | Усан болон мөсөн парк барих боломж бүхий газартай | Хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, паркийг барьж байгуулах | Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх газар нэмэгдсэн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ГХБХБГ, БОАЖГ |
| 86 | 30 | Ажлын хэсгийн санал | Нутгийн удирдлагын ордоны шинэ барилгын зураг төсөв хийлгэх | 1958 онд баригдсан барилгатай. | Хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж магадлалаар батлагдсан иж бүрэн зураг төсөвтэй болсон байна. | Тав тухтай орчноос төрийн үйлчилгээг авах боломж бүрдэнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ГХБХБГ |
| 87 | 31 | ОНӨГ-ын санал | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг аймгийн хэмжээнд 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулан мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллах | Аймгийн хэмжээнд худалдан авах ажиллагааны 68 хувь нь цахим хэлбэрээр явагдаж байна. | Цахим хэлбэрээр зохион байгуулах хууль эрхзүйн сургалт зохион байгуулна. | Мэдээллийн ил тод байдал нэмэгдсэн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | ОНӨГ |
| 88 | 32 | - | Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшиж буй хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, эзэмшиж буй газарт дахин үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулинд 9 жилд 1 удаа дахин үнэлгээ хийж байхаар тусгагдсан. 2009 онд дахин үнэлгээ хийсэн. | Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, эзэмшиж буй газарт дахин үнэлгээ тогтоосон байна. | Эдийн засгийн үр өгөөж нэмэгдсэн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | ОНӨГ |

| 1.5 Санхүү, төсвийн бодлого | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтыг оновчтой болгон, төсвийн сахилга бат, шилэн дансны хяналт, ил тод байдлыг эрхэмлэж, иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэгийг дээшлүүлнэ.** | | | | | | | | |
| 89 | 1 | ЗГҮАХ-ийн 1.4, 1.9, АЗДҮАХ-ийн 1.5.1 | Төсвийн орлогын бүрдүүлэлт, төсвийн гүйцэтгэлийн тайланг сар бүр Шилэн дансны цахим хуудас, аймгийн вэб сайтанд байршуулж, төсвийн ил тод байдлыг хангах | Шилэн дансны цахим хуудсанд 11 төрлийн мэдээлэл, аймгийн вэб сайт болон ил тод байдлын самбарт 10 мэдээлэл байршуулж байна. | Аймгийн цахим хуудас болон ил тод байдлын самбарт мэдээллийг ил тод, бүрэн мэдээлдэг болно. | Төсвийн ил тод байдал хангагдан мэдээллийн хүртээмж дээшилнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, Төсвийн байгууллагууд |
| 90 | 2 | | Сумдын Санхүүгийн албаны мэргэшил, чадварыг дээшлүүлэх, ажлын байранд нь дадлага туршлага нэмэгдүүлэх сургалтын шинэ хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх | 2017 оны жилийн эцсийн аудитын тайлангаар аймаг болон 5 сум “Хязгаарлалттай” дүгнэгдсэн. Энэ нь төсвийн сахилга бат сул байгаагийн илрэл болно. | Сумдын санхүүгийн албаны мэргэшил, чадвар дээшилж, 2018 оны аудитын тайлангаар гарах алдаа дутагдал эрс буурсан байна. | Сумдын санхүүгийн албаны мэргэшлийн чадвар дээшилж, төсвийн сахилга бат сайжирна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ,Сумдын санхүүгийн алба |
| 91 | 3 | | Төрийн сангийн үйл ажиллагааны талаар аймгийн хэмжээнд сэтгэл ханамжийн судалгаа хийж, үр дүнг тайлагнах | 2017 онд дотоод хяналтад хамрагдсан төрийн сангийн нэгжийн нийт 36 харилцагч байгууллагаас судалгаа авахад 29.0 хувь нь төрийн сангийн үйл ажиллагаанд сэтгэл хангалуун бус, 8.3 хувь нь зан харилцааны | Төрийн сангийн үйл ажиллагааны сэтгэл ханамжийн судалгааны үр дүн гарна. Үр дүнд суурьлан цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах боломж бүрдэнэ. | Төрийн сангийн үйл ажиллагааг сайжруулахад шаардлагатай мэдээлэл цугларч, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | доголдол гаргадаг, 33.3 хувь нь ажлын цагаа баримталдаггүй, 21.4 хувь нь төрийн сангийн албан хаагчдын мэдлэг чадварыг хангалтгүй гэж үзсэн байна. | | | | |
| **Татвар төлөгчийн хүрээг өргөтгөж, татвар хураалтыг сайжруулан, орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |
| 92 | 4 | АЗДҮАХ-ийн 1.5.2 | Бүртгэлгүй орлого болон орлогоос бусад татвар ногдох зүйлийг илрүүлэн татвар төлөгчийн суурийг өргөжүүлж төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр жигд хангaн биелүүлэх | Аймгийн хэмжээнд 3803 татвар төлөгч аж ахуйн нэгж байгууллага, 41200 татвар төлөгч иргэн байна. | Батлагдсан төсвийн дагуу орлогын нэр төрлөөр нь жигд хангaн биелүүлнэ. | Татвар төлөгчийн суурь өргөжин татварын орлого нэмэгдэнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Татварын хэлтэс |
| 93 | 5 | | Нэмэгдсэн өртгийн албан татварын баримт хэвлэх цэгүүдийн тоог нэмэгдүүлэн худалдаа, үйлчилгээ эрхлэгч болон үйлчлүүлэгч нарт зориулсан сургалтыг зохион байгуулж, нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийн хэрэгжилтэнд хяналт тавих. | Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгжүүд 100.0 хувь, суутган бус татвар төлөгч иргэн аж ахуйн нэгжүүдийн 80 хувь нь баримт хэвлэх машинаар хангагдсан байдаг. Аймгийн хэмжээнд нийт 1980 баримт хэвлэх машин тархаагдсан байна. | Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийг 100 хувь, үйл ажиллагаа тогтмол явуулдаг суутган төлөгч бус татвар төлөгчийн 90.0 хувийг хамруулж, баримт хэвлэх цэгийн тоог 2200 болгоно. Сургалтанд 3500 орчим худалдаа эрхлэгч, үйлчлүүлэгч нарыг хамруулсан байна. | Худалдаа эрхлэгч, үйлчлүүлэгчдийн мэдлэг дээшилж, нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийн хэрэгжилт эрчимжинэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Татварын хэлтэс |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 94 | 6 | | Татварын хуулийн хэрэгжилтийг ханган, татвар төлөгчдөд татварын боловсрол олгох ажлын байрны болон танхимын сургалтыг тогтмолжуулах | Жилд давхардсан тоогоор 7500 татвар төлөгчдийг сургалтад хамруулдаг. | Давхардсан тоогоор 7800 татвар төлөгчийг сургалтанд хамруулж гарын авлага материалаар хангана. | Татвар төлөгчдийн мэдлэг дээшилж, татвараа өөрөө үнэн зөв тодорхойлон хугацаанд нь төлөх хандлага бүрдэн Татварын хуулиудын хэрэгжилт хангагдсан байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Татварын хэлтэс |
| **Санхүүгийн хяналт, дотоод аудитын үйл ажиллагааг эрчимжүүлж, “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”-ыг хэрэгжүүлэн, төсвийн сахилга батыг сахиулж, зөрчил дутагдалгүй ажиллана.** | | | | | | | | |
| 95 | 7 | ЗГҮАХ-ийн 1.4, АЗДҮАХ-ийн 1.5.3 | Төсөвт байгууллагууд, сан, хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагад эрсдлийн үнэлгээ хийж, өндөр болон дунд эрсдэлтэй байгууллагыг хяналт шалгалт, аудитад хамруулах | Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяаны 212 байгууллагад эрсдлийн үнэлгээ хийж өндөр болон дунд эрсдэлтэй 85 байгууллагад дотоод хяналт шалгалт, аудитад хамруулан зөрчлийг арилгуулах 155 зөвлөмж, 15 дүгнэлтийг гаргаж, биелэлтэд хяналт тавьж ажилласан. | Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяаны 212 байгууллагад эрсдлийн үнэлгээ хийж, 35 байгууллагад дотоод аудит, 62 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийнэ. | Санхүүгийн зөрчил, дутагдал буурч, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа сайжирна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Санхүүгийн хяналт, аудитын алба |
| 96 | 8 | | Хяналт шалгалт, аудитын үр дүнд хөрөнгийн үр өгөөжийг сайжруулах, илэрсэн зөрчил, дутагдлыг | Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын үр дүнг удирдлагад болон аймаг, сумын ИТХ-д танилцуулан, | Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудад өгөгдсөн үүрэг даалгавар, зөвлөмжийн биелэлтэд хяналт | Санхүүгийн хяналт шалгалт, аудитын үр нөлөө болон санхүүгийн сахилга бат дээшилнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Санхүүгийн хяналт, аудитын алба |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хханган ажиллах | зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. | тавьж, 2018 оны төлбөрт зөрчлийн үлдэгдлийг бүрэн барагдуулна. | | | |
| 97 | 9 | | Мэргэшсэн Нягтлан бодогчдын институттай хамтран Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох сургалтыг зохион байгуулах | Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 1600 орчим нягтлан бодогч ажилладаг бөгөөд үүний 2.8 хувь буюу 45 нь мэргэшсэн нягтлан бодогч байна. Энэ бусад аймгуудтай харьцуулахад хамгийн бага хувьтай байна. | Нягтлан бодогчдын мэдлэг, мэргэшлийн түвшин дээшилж, нягтлан бодох бүртгэл, хөтлөлт сайжирна. | Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг хэрэгжүүлэн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа сайжирна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | АЗДТГ, Санхүүгийн хяналт, аудитын алба |
| 98 | 10 | | Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа төсөвт байгууллагуудад санхүүгийн зөрчлийг арилгах явцын хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг зохион байгуулж, тогтмолжуулах | 2017 оны жилийн эцсийн аудитын тайлангаар аймаг болон 5 сум “Хязгаарлалттай” дүгнэгдсэн. | Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяаны 212 байгууллагад санхүүгийн явцын хяналт шалгалт хийж санхүүгийн зөрчилгүй болсон байна. | Төсөв, санхүүгийн сахилга бат дээшилж, аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авсан байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, төсвийн ил тод байдлыг хангана.** | | | | | | | |
| 99 | 11 | АЗДҮАХ-ийн 1.5.4 | Шилэн дансны мэдээлэл байршуулалт хангалтгүй дүнтэй байгаа төсөвт байгууллагуудын | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжиж, хяналт тавьж байгаа боловч мэдээлэл байршуулалт 92.2 | Сургалтанд хамрагдсан байгууллагуудын удирдлага, санхүүгийн ажилтнуудын | Шилэн дансны цахим хуудсанд мэдээ мэдээлэл бүрэн байршиж, хэрэглэгчдэд хүрэх | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Санхүүгийн хяналт, аудитын алба |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | удирдлага, санхүү бүртгэлийн ажилтнуудад шилэн дансны тухай хууль, журмын талаар ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулж, хууль журмын хэрэгжилтийг хангуулах | хувь байна. | Шилэн дансны тухай хууль, журмын мэдлэг дээшилж, мэдээллийг бүрэн байршуулдаг болгоно. | мэдээллийн цар хүрээ нэмэгдэнэ. | | |
| 100 | 12 | | Шилэн дансны цахим сайтад мэдээллийг хуулийн хугацаанд үнэн байршуулсан эсэхэд улирал тутам аудит хийж, үр дүнгийн талаар аймгийн цахим сайт, бусад мэдээллийн хэрэгслээр мэдээллэх | Тайлант онд 260 байгууллагын Шилэн дансанд мэдээлэл байршуулсан эсэхэд аудит хийж, улирал бүр мэдээллийн талаар цахим сайтад мэдээлж, байна. | Улирал тутам аудит хийж, Шилэн дансны мэдээлэл байршуулалтыг чанаржуулах ажил зохион байгуулна. | Төсвийн ил тод байдал болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Санхүүгийн хяналт, аудитын алба |
| **Аймгийн Статистик мэдээ мэдээллийн үнэн бодит байдал,чанарыг дээшлүүлж, олон нийтэд нээлттэй хүртээмжтэй хүргэнэ.** | | | | | | | | |
| 101 | 13 | АЗДҮАХ-ийн 1.5.5 | Орон нутгийн статистик мэдээ хариуцсан ажилтнуудыг чадваржуулж, мэдээллийн тархаалтыг сайжруулах | 2018 онд сумын статистик хариуцсан ажилтнууд, багийн Засаг дарга нарт сургалт зохион байгуулагдаагүй болно. | 17 сумын статистик хариуцсан ажилтнууд, багийн Засаг дарга нарыг сургалтанд хамруулна. Иргэд, байгууллага шаардлагатай мэдээ, мэдээллээр хангагдана. | Орон нутгийн статистик мэдээ хариуцсан ажилтнуудын чадвар сайжирч, статистик мэдээллийн үнэн бодит байдал, чанар дээшилнэ. Мэдээллийн тархаалт сайжирсан байна. | Төсвийн байгууллагын хөрөнгөөр | Үндэсний Статистикийн хороо, Статистикийн хэлтэс |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Санхүүгийн зах зээлийг орон нутагт эрчимжүүлэх ажлыг зохион байгуулна.** | | | | | | | | |
| 102 | 14 | ЗГҮАХ-ийн 2.6, Сэлэнгэ аймгийн хөгжлийн хөтөлбөр, АЗДҮАХ-ийн 1.5.6 | “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд төлөвлөгөө боловсруулан иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх ажил, арга хэмжээ зохион байгуулах | “Санхүүгийн боловсрол” аяныг амжилттай зохион байгуулж, 2172 сурагчдад санхүүгийн суурь мэдлэг олгосон. | Иргэдийн санхүүгийн боловсрол дээшилнэ. | Иргэдийн санхүүгийн зах зээлийн талаарх мэдлэг болон санхүүгийн зөв шийдвэр гаргах чадварыг дээшлүүлж, хөрөнгийн зах зээлийг орон нутагтаа идэвхижүүлнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ |
| 103 | 15 | АЗДҮАХ-ийн 1.5.6 | Санхүүгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудад хяналт шалгалт зохион байгуулж, үйл ажиллагааг идэвхжүүлэх | Аймгийн хэмжээнд 11 даатгалын компани, 1 брокер дилерийн компани, 2 хадгаламж, зээлийн хоршоо, 5 банк бус санхүүгийн байгууллага, 1 хохирлын үнэлгээний компани үйл ажиллагаа явуулж байна. | Санхүүгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулж, иргэдэд шуурхай үйлчилдэг болгоно. | Санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаа орон нутагт эрчимжинэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ |
| **ХОЁР. НИЙГМИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| **2.1.Эрүүл мэндийнбодлого:** | | | | | | | | |
| **Салбарын хүний нөөцийг чадавхижуулан, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, оношилгоо, эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ.** | | | | | | | | |
| 104 | 1 | АЗДҮАХ-ийн 2.1.1.1 | Эмч, эмнэлгийн ажилтнуудын мэдлэг, ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх ажлыг зохион байгуулах | 2018 оны байдлаар эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, ажилтнуудын багц цаг, зайн, ажлын байрны болон | Эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, ажилтнуудын багц цагийн, зайн, ажлын байрны болон танхимын | Эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, ажилтнуудын сургалтад хамрагдагсдын хувь нэмэгдэж, | Аймаг, сумын орон нутгийн төсвийн болон Эрүүл мэндийн газрын хөрөнгөөр | ЭМГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | танхимын сургалтад нийт эрүүл мэндийн салбарын 1317 ажилтны 60 хувийг хамруулсан. | сургалтуудын хамрагдалтыг нийт ажилчдын 70 хувьд хүргэсэн байна. | мэргэжлийн, ур чадвар дээшилнэ. | | |
| 105 | 2 | АЗДҮАХ-ийн 2.1.1.2 | Аймгийн хэмжээнд нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж, бэлтгэх | 2018 онд 25 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг нэн шаардлагатай мэргэшүүлэх болон төрөлжсөн мэргэжлийн сургалтад хамруулж, одоогоор 5 их эмч үндсэн мэргэжил олгох сургалтад үргэлжлүүлэн сурч байна. | Нэн шаардлагатай байгаа нарийн мэргэжлийн 40 эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэнг хуваарийн дагуу төрийн сан, байгууллага, хувийн зардлаар үндсэн болон мэргэшүүлэх сургалтад үе шаттайгаар хамруулсан байна. | Дутагдалтай байгаа нарийн мэргэжлийн эмчийн хүрэлцээ, хангамж сайжирч, иргэдэд хүргэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж дээшилнэ. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | ЭМГ |
| 106 | 3 | АЗДҮАХ-ийн 2.1.1.3 | Эмч, эмнэлгийн ажилчдыг байртай болоход дэмжлэг үзүүлж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх | Эмч, эмнэлгийн ажилчдын орон сууцны хангамж муу улмаас залуу боловсон хүчин тогтвор суурьшилтай ажиллахгүй байна. | Эрүүл мэндийн салбарын хэмжээнд түрээсийн орон сууцанд амьдарч байгаа 80 гаруй эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэнг орон сууцтай болгох асуудалд дэмжлэг үзүүлэх, нэн шаардлагатай байгаа нарийн мэргэжлийн эмчийн орон сууцны асуудлыг шийдвэрлэсэн байна. | Залуу эмч, эмнэлгийн ажилчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн баталгааг хангасан байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ЭМГ, АНЭ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 107 | 4 | АЗДҮАХ-ийн 2.1.2. | Эмч, эмнэлгийн ажилтны ёс зүйн хариуцлагыг сайжруулж үр дүнг тооцох | Зайн болон багц цагийн сургалтаар давхардсан тоогоор нийт 650 эмч, эмнэлгийн мэргэжилтэн бусад ажилтанг ёс зүйн сургалтанд хамруулсан. Сургалтын үр дүнд эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний талаарх мэдлэг, хандлага 83 хувьтай болж дээшилсэн. | Ёс зүйн сургалтыг тогтмолжуулж, хамрагдагсдын тоог нэмэгдүүлсэн байна. | Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харьцаа хандлага сайжирч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчилгүй ажиллана. | Улсын төсвийн хөрөнгөөр | ЭМГ |
| 108 | 5 | АЗДҮАХ-ийн 2.1.3.1 | Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийг үргэлжлүүлэн зохион байгуулж хүн амын мэдээллийн цахим сан үүсгэх | Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн цогц үзлэг оношилгоог 11 сум, 3 тосгонд зохион байгуулж, хамрагдвал зохих 47516 иргэнээс 28509 буюу 60 хувийг хамруулж, 23 иргэнийг 3 дахь шатлалын эмнэлэгт илгээж, өвчтэй илэрсэн 19956 иргэнийг анхан болон 2 дахь шатлалын эмнэлгийн хяналтанд авч ажиллаж байна. | Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн цогц үзлэг оношлогоог Алтанбулаг, Шаамар, Орхонтуул, Баруунбүрэн сум, Рашаант, Бугант, Номгон тосгонд тус тус зохион байгуулж, иргэдийн 70-аас дээш хувийг хамруулсан байна. | Хүн амын дунд халдварт болон халдварт бус өвчнийг эрт илрүүлж, эмчилгээ хяналтанд авч эмчилэн эрүүлжүүлнэ. Орон нутгийн хүн амд хүрч үйлчлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг ойртуулснаар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж дээшилнэ. | Аймаг, сумын орон нутгийн төсвийн болон Эрүүл мэндийн газрын хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ЭМГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 109 | 6 | АЗДҮАХ-ийн 2.1.3.2 | Иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах | 1.Аймгийнхэмжээн дамбулаторийн үзлэгт эзлэх урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь 28.2байна. 2.Өвөлжилтхүндэр сэн 3 сум, тосгоны 554 иргэнд нарийнмэргэжлийн эмчийнтусламжийг үзүүлсэн. 3.УИХ-ын гишүүний дэмжлэгтэйгээр 3 сум 2 тосгонд хавдрын эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулж, 3590 иргэнийг хамруулснаас шинэ хавдар 15, сэжигтэй 14 тохиолдлыг илрүүлэн Хавдар судлалын үндэсний төвийн хяналтанд шилжүүлсэн. | Нийтамбулаторийн үзлэгт эзлэх урьдчилансэргийлэ хүзлэгийн хувийг 42 хувьдхүргэж, өвөлжилт хүндэрсэн сумдын малчид, тариаланчдын судалгааг гаргаж, явуулын амбулаторийн тусламжийг үзүүлсэн байна. | Аймаг, сумын төвөөс алслагдсан иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй хүргэснээр өвчлөлийг эрт үед нь илрүүлж, хүндрэлээс сэргийлнэ. | Аймаг, сумын орон нутгийн төсвийн болон Эрүүл мэндийн газрын хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ЭМГ |
| 110 | 7 | АЗДҮАХ-ийн 2.1.4 | “Бид Сэлэнгийн ирээдүй” аймгийн хөтөлбөрийн хүрээнд “Эрүүл хүүхэд – Сэлэнгийн ирээдүй” төслийг хэрэгжүүлэх | 2017 оны статистик үзүүлэлтээр хүүхэд, өсвөр үеийхний дунд бөөр, шээс дамжуулах замын өвчлөл, амьсгал, хоол боловсруулах замын өвчлөл зэрэг халдварт болон халдварт бус өвчний | Хүүхэд, өвсөр үеийнхнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж охид, хөвгүүд, бага насны хүүхдэд зонхилон тохиолдох өвчлөлийг эрт илрүүлэн эмчлэн эрүүлжүүлнэ. Эрүүл шүд аяны | Өсвөр насны охид, хөвгүүдийн эрүүл мэндийн мэдээллийн сантай болж хүсээгүй жирэмслэлт бэлгийн замаар дамжих халдвар, дэлгэцийн донтолтонд өртөх эрсдлээс | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ЭМГ, АНЭ, Сум дундын эмнэлэг, Сум, тосгоны Эрүүл мэндийн төв |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тохиолдол 8753 буюу 23 хувийг эзлэж байна. 0-6 хүртэлх насны 5 хүүхэд тутмын 3 нь шүд цоорох эмгэгтэй, дунджаар 1 хүүхдийн 2-6 шүд өвчтэй байна. Охидын төрөлт 129, өсвөр насныханы бэлгийн замаар дамжих халдварт өвчний 32 тохиолдол бүртгэгдэж эмчлэгдсэн байна. Хүүхэд, өсвөр үеийнхний дунд компьютер, ухаалаг утасны хэт хэрэглээний улмаас сэтгэцийн эрүүл мэндийн сөрөг нөлөөлөл нэмэгдэх хандлагатай байна. | хүрээнд 2-12 насны хүүхдийн шүдний цоорлын эрчмийг бууруулсан байна. | сэргийлж эрт эмчлэн эрүүлжүүлнэ. 2-5 насны хүүхдийн сүүн шүдлэлтийн үед цаг алдалгүй шүд хамгаалах түрхлэг түрхсэнээр цоорлын тархалтыг 20 хувиар бууруулна. | | |
| 111 | 8 | АЗДҮАХ-ийн 2.1.5 | “Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, “Эх, нялхсын эндэгдэлгүй аймаг, сум, баг” болох хөдөлгөөн өрнүүлж, үр дүнд хүргэх | Эх, хүүхэд, Нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл байгуулагдаагүй байна. Аймгийн хэмжээнд эхийн эндэгдэл бүртгэгдээгүй ба 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 15 | Салбар хоорондын “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл”-ийг үйлчлүүлэгч, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор байгуулна. Эхийн эндэгдэлгүй, 5 хүртэлх насны | Салбар зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжиж, хөтөлбөрийн хэрэгжилтэнд тавих хяналт сайжирсан байна. Эхийн эндэгдэлгүй ажиллаж, 5 хүртэлх насны хүүхдийн | Төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр | ЭМГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тохиолдол гарч 1000 амьд төрөлтөд 13,1 промил байна. | хүүхдийн эндэгдлийг улс, аймгийн дунджаас 7.0 промиллээр бууруулсан байна. | эндэгдлийг бууруулна. | | |
| 112 | 9 | АЗДҮАХ-ийн 2.1.5.1 | “Эх, хүүхдэд ээлтэй сум” болзолт уралдааны удирдамжийг шинэчлэн, шалгаруулалтыг зохион байгуулах | 2014 оноос хойш “Эх хүүхэд ээлтэй сум” болзолт уралдаан зохион байгуулагдаагүй. | Эх, хүүхдэд ээлтэй сум” шалгаруулах болзолт уралдаан зарлаж, дүгнэсэн байна. | Эх, хүүхдэд ээлтэй орчин нөхцөл бүрдэж,эх хүүхдийн эрүүл мэнд сайжирсан байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ЭМГ |
| 113 | 10 | АЗДҮАХ-ийн 2.1.8 | Хүн амын дунд элэгний хатуурал, хорт хавдар, В, С вирус илрүүлэх үзлэгийг үе шаттайгаар зохион байгуулж, оношийг баталгаажуулан эмчилгээнд хамруулах | Элэгний В, С вирусын эрт илрүүлэг үзлэгийг 2018 оны 10 дугаар сарын 03-аас эхлэн 15-39 насны хамрагдвал зохих 22337 иргэнээс 2018 оны 10-р сарын 09-ны өдрийн байдлаар 23,5хувийг хамруулаад байна. | Элэгний В, С вирусын эрт илрүүлэг үзлэгт иргэдийг бүрэн хамруулж, эрүүлжүүлэх ажлыг эхлүүлсэн байна. | Вирусын гаралтай элэгний хатуурлын өвчлөл, нас баралтын тохиолдол буурна. | Төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр | ЭМГ |
| 114 | 11 | АЗДҮАХ-ийн 2.1.9.1 | “Сүрьеэгүй Сэлэнгэ” аймгийн хөтөлбөрийн хүрээнд өвчлөл өндөртэй сум, тосгонд сүрьеэгийн хавьтлын судалгааг гарган эрт илрүүлэх үзлэгийг зохион байгуулах | 10000 хүн амд сүрьеэгийн өвчлөл 11.7 промил байна. Аймгийн 11 сум, 3 тосгодод хавьтлын үзлэг оношилгоог зохион байгуулж, илэрсэн өвчлөлийг эмчилгээнд хамруулсан. | Хавьтлын судалгааг гаргаж, эрт илрүүлгийн үзлэгт хамруулж, илэрсэн өвчлөлийг 100 хувь эмчилгээнд хамруулсан байна. | Сүрьеэгийн шинэ тохиолдлыг илрүүлснээр халдварын тархалтыг хязгаарлаж, сүрьеэтэй холбоотойгоор гарах хүндрэлээс сэргийлнэ. | Аймаг, сумын орон нутгийн төсвийн болон Эрүүл мэндийн газрын хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ЭМГ |
| 115 | 12 | АЗДҮАХ-ийн 2.1.9.2 | Хүн амын дунд түргэвчилсэн оношлуураар ХДХВ, ДОХ бэлгийн замаар | 10000 хүн амд трихомониаз 16,4, заг хүйтэн 5,9, тэмбүү 15,1 промил байна. | Илрүүлэг үзлэгийн мөрөөр илэрсэн өвчлөлийн 80-аас доошгүй хувийг эмчилсэн байна. | Хүн амын дунд бэлгийн замаар дамжих халдварын тархалт буурна. | Аймаг, сумын орон нутгийн төсвийн болон Эрүүл мэндийн газрын | ЭМГ, Бүх шатны эрүүл мэндийн байгууллага |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дамжих халдварыг эрт илрүүлэх үзлэг, хяналтыг сайжруулах | Аймгийн 14 сум, тосгоны 11422 хүн хамруулж, тэмбүүгийн 135 тохиолдол бүртгэгдэж, эмчилгээ хяналтанд авсан. | | | хөрөнгөөр | |
| 116 | 13 | АЗДҮАХ-ийн 2.1.10 | Зоонозын халдварт өвчин, шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний байгалийн голомтын болон хүн амын дунд тандалт судалгаа, эрсдлийн үнэлгээг хийж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах | Сэлэнгэ аймаг нь хачигт халдвар, боом, галзуу, бруцеллёз, хулгана тахал зэрэг өвчлөлийн байгалийн голомттой. 2004-2018 онд нийт хачгаар дамжих халдварын 306 өвчлөл тохиолдсон. Үүнтэй холбоотойгоор байгалийн голомтын тандалт судалгаа, шинжилгээг тасралтгүй тогтмол хийх шаардлагатай. Мөн хил орчмын гол мөрний усанд (Сэлэнгэ мөрөн, Зэлтэр гол, Бааст гол, Цөх гол, Хяраагы гол) холер өвчний шинжилгээг жилд 5 цэгт газраас (1 цэгт газраас 2 сорьц дээжлэн авдаг) 2 | Зоонозын халдварт өвчний байгалийн төлөв байдлыг судлан тогтоож шинжилгээний үр дүнг баталгаажуулна. Урьдчилан сэргийлэх тарилга бүхий Хачигт энцефалитын дархлаажуулалтын хамрагдалт нэмэгдсэн байна. Хил орчмын гол мөрний уснаас холер өвчний шинжилгээг авч, баталгаажуулсан байна. | Голомтот нутгийн ард иргэдийн тухайн нутагт оршиж буй зоонозын өвчний талаарх мэдлэг хандлага сайжирч, Өвчлөлийн тохиолдол буурна. Байгаль нуурыг хамгаалах 2 улсын гэрээ биелнэ. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | ЭМГ, ЗӨСТ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | удаагийн давтамжтай нийт 20 сорьц шинжилж байна. | | | | |
| 117 | 14 | АЗДҮАХ-ийн 2.1.14 | Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлж, Антибиотик эмийг жороор олгодог болгох ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох | Эмийн замбараагүй хэрэглээ ихсэж, үүний улмаас антибиотик эмэнд нянгийн тэсвэржилт үүсэж байна. | Аймгийн хэмжээнд эмийн зохистой хэрэглээний талаарх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, мэдээлэл сургалт сурталчилгааг тогтмолжуулсан байна. | Иргэдэд эмийн зохистой хэрэглээ төлөвшсөн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | ЭМГ, Бүх шатны эрүүл мэндийн байгууллага |
| 118 | 15 | АЗДҮАХ-ийн 2.1.18 | Сүхбаатар сумын өрхийн эрүүл мэндийн төвүүдийг зохион байгуулалтад оруулж, байртай болгох асуудлыг шийдвэрлэх | Сүхбаатар суманд өрхийн 2 эрүүл мэндийн төв стандартын шаардлага хангасан байргүйн улмаас иргэдэд үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй байна. | Сүхбаатар суманд стандартын шаардлага хангасан 1 өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын асуудлыг шийдвэрлүүлсэн байна. | Стандартын шаардлага хангасан 1 өрхийн эрүүл мэндийн төвийн байртай болно. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, Сүхбаатар сумын ЗДТГ, ЭМГ |
| 119 | 16 | АЗДҮАХ-ийн 2.1.19.1 | Эрүүл мэндийн төвүүдийг оношлогооны тоног төхөөрөмж болох “Мобайл технологи”, “Зөөврийн ЭХО”-аппаратаар хангах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх | Сэлэнгэ аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн газар, Зүүнбүрэн сумын эрүүл мэндийн төв Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хөрөнгө оруулалтаар мобайл технологийн зөөврийн эхо аппаратны иж | Жавхлант, Цагааннуур, Түшиг, Хушаат сум, Дулаанхаан тосгоны эрүүл мэндийн төвүүдэд “Мобайл технологи”-ийг нэвтрүүлж , “Зөөврийн ЭХО” аппаратаар сум, тосгодыг үе шаттайгаар хангасан байна. | Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж дээшилж алслагдсан иргэдэд эхо шинжилгээ хийх боломжтой болно. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ЭМГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бүрдэлээр хангагдаад байна Алтанбулаг, Орхон, Хушаат сум, Бугант, Дулаанхаан, Түнхэл, Рашаант, Хэрх, Номгон тосгодын эрүүл мэндийн төвүүд зөөврийн эхо аппаратгүй байна. | | | | |
| 120 | 17 | АЗДҮАХ-ийн 2.1.19.2 | Эрүүл мэндийн төвүүдийн автомашины парк шинэчлэлтийг нэмэгдүүлж, эмнэлгийн барилга, барилгын өргөтгөлийг үе шаттайгаар шийдвэрлүүлэх | Мандал сумын Нэгдсэн эмнэлэг, Алтанбулаг, Баянгол, Жавхлант, Орхонтуул, Сант сумд, Бугант тосгоны эрүүл мэндийн төв, Зоонозын өвчин судлалын төвүүдийн түргэн тусламжийн автомашины гүйлтийн норм дууссан. Мандал, Сүхбаатар сумдын өрхийн эрүүл мэндийн төвүүд, барилгын насжилтыг тодорхойлох болон Алтанбулаг, Жавхлант, Хүдэр сумдын эрүүл мэндийн төвүүдийн барилга, барилгын | Гүйлтийн норм дууссан автомашинуудын парк шинэчлэлтийг үе шаттайгаар нэмэгдүүлж, , судалгаа тооцоо ажлын зураг төсөв дээр үндэслэн барилга, барилгын өргөтгөл барих ажил үе шаттайгаар хийгдсэн байна. | Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж дээшилнэ. | Улсын төсвийн хөрөнгөөр | ЭМЯ, Аймгийн ЗДТГ, ЭМГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | өргөтгөл хийх шаардлагатай байна. | | | | |
| 121 | 18 | АЗДҮАХ-ийн 2.1.19.3 | “Эрүүл мэндийн хөгжил-5” төслийн хүрээнд аймгийн нэгдсэн эмнэлгийн цусны банк, ариутгалын хэсэг, эмнэлгийн гаралтай хог хаягдлын менежментийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх | “Эрүүл мэндийн хөгжил 5” төслийн биелэлт 40-45 хувьтай байна. | Төслийн биелэлтийг 90 хувьд хүргэсэн байна.. | Эмнэлгийн гаралтай халдвар гарахаас бүрэн сэргийлнэ. | Төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр | ЭМГ, АНЭ |
| 122 | 19 | ЭМГ-ын санал | Анхан болон лавлагаа шатны тусламж үйлчилгээг эрс сайжруулж, нэгдсэн эмнэлгүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, төрөх, хүүхэд, гэмтэл, мэс заслын тусламж үйлчилгээг өргөжүүлж, чирэгдлийг бууруулах | Нэгдсэн эмнэлгийн амбулаторид хүлээгдлийн хувь 7.2-8.9 байгаа ба 38-112 үйлчлүүлэгчид 7 кабинетэд 5 хүртэл хоногоор хүлээгдэл үүсч байна. | Хүлээгдлийн хувийг 5 хувиас хэтрүүлэхгүй. байна. | Хүлээгдэл чирэгдэл буурч, иргэдийн сэтгэл ханамж, нэмэгдэнэ. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | ЭМГ, АНЭ |
| 123 | 20 | ЭМГ-ын санал | Аймгийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийг хүний нөөцөөр хангах асуудлыг шийдвэрлэх | Аймгийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн яаралтай тусламжийн хэсгийг зохион байгуулан, 126 сая төгрөгний засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжөөр хангасан. | Хүүхдийн яаралтай тусламжийн их эмч, сувилагч тус бүр 1-ийг орон тоогоор ажиллуулж, яаралтай тусламжийн үйл ажиллагааг жигдрүүлнэ. | Хүүхдэд үзүүлэх яаралтай тусламжийн чанар сайжирна. Өвчлөл, нас баралт буурна. | Улсын төсвийн хөрөнгөөр | ЭМГ, АНЭ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Яаралтай тусламжийн тасагт ажиллах их эмч, сувилагч дутагдалтай байна. | | | | |
| 124 | 21 | ЭМГ-ын санал | 0-3 насны суурь өвчтэй хүүхдүүдийг эцэг эх асран хамгаалагчийн хамт эмгүйгээр эмчлэн эрүүлжүүлж чийрэгжүүлэх зуны сувиллыг Сүхбаатар суманд байгуулж ажиллуулах | Буман нарс ахмадын сувилалд түшиглэн суурь өвчтэй хүүхдүүдийг сувилдаг байсан боловч, тус сувиллын газрын асуудлаас болоод түр зогссон байна. | Буман нарс сувиллыг шинээр зохион байгуулах газрын асуудлыг шийдвэрлэж аймгийн нэгдсэн эмнэлгийн дансанд бүртгэлтэй байгаа барилгыг шинэ газарт нүүлгэн шилжүүлж, өргөтгөсөн байна. | Эмгүй эмчилгээний хүрээ өргөжин, ахмад настан, хүүхдийн өвчлөл буурна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ЭМГ, АНЭ |
| 125 | 22 | АИТХурлаас гарсан санал | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүчилтөрөгчийннэг дсэн систем суурьлуулах | Дархан-Уул аймгийн Дулааны станцаас сардаа 8-10 ширхэг баллоныг тээвэрлэн, 1 баллоны өртөгт 41.000 төгрөгийг зарцуулж байна. | Хүчилтөрөгч шаардлагатай өвчтөнд цаг алдалгүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байна. | Өвчтөний амь насыг шуурхай аварч, эндэгдлийг бууруулна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ЭМГ, АНЭ |
| 126 | 23 | АИТХурлаас гарсан санал | Мандал сумын Нэгдсэн эмнэлгийг гемодиализын аппаратаар хангах | Мандал сумын 12 иргэн 7 хоногт 3 удаа диализын аппаратаар эмчлүүлж байна. Үүнээс 9 иргэн Аймгийн Нэгдсэн эмнэлэгт, 3 иргэн Улаанбаатар хотод хувийн эмнэлэгт эмчлүүлж байна. | Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийг тусламж үйлчилгээ ойртсон байна. | Бөөрний дутагдлын өвчлөл, нас баралтын тохиолдлыг бууруулна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ЭМГ, МСНЭ |
| **2.2. Боловсролын бодлого:** | | | | | | | | |
| **Бүх шатны боловсролын байгууллагуудад сурч боловсрох, хөгжих, ажиллах, амьдрах, эрүүл аюулгүй, ээлтэй орчныг бүрдүүлж, боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэнэ.** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 127 | 1 | ЗГҮАХ 3.2.2, АЗДҮАХ-ийн 2.1.1 | Сүхбаатар суманд 150, Цагааннуур суманд 150, Алтанбулаг суманд 50, Орхонтуул сумын Рашаант тосгонд 75, нийт 425 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг байгуулах | Сүхбаатар, Цагааннуур, Алтанбулаг, Орхонтуул суманд СӨБ-ийн хамран сургалт хангалтгүй байна. | Сүхбаатар, Цагааннуур, Алтанбулаг, Орхонтуул суманд цэцэрлэг ашиглалтад орсноор 425 хүүхэд шинээр цэцэрлэгт хамрагдах боломж бүрдэнэ. | Цэцэрлэгийн хүртээмж нэмэгдэж, хүүхэд эрүүл өсч, хөгжих нөхцөл сайжирсан байна. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, БСУГ |
| 128 | 2 | БСШУСЯ-ы 2018-2019 оны зорилт | Бүх түвшинд сургалтын чанарыг ахиулж, үр дүнг тооцон, суралцах идэвхийг урамшуулан дэмжиж ажиллах | 2017-2018 оны хичээлийн жилд бага боловсролын улсын шалгалтын гүйцэтгэл 76.3 хувь, онц, сайн дүнгийн эзлэх хувь Монгол хэл 6.1 хувь, Математик 1.2 хувь, Хүн ба байгаль 11.7 хувиар ахисан байна.<br>Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдээс авсан улсын шалгалтын нэгтгэсэн дүнг өмнөх онтой харьцуулвал стандарт хангалт 100 хувь, A, B үнэлгээний эзлэх хувь буюу чанар 4.3 хувиар ахисан үзүүлэлттэй байна. | Хүүхэд бүрийг хөгжүүлэх, сургалтын чанарыг дээшлүүлэх боломж бүрдсэн байна. ЭЕШ, улсын олимпиадад амжилттай оролцсон багш, сурагчдад Аймгийн Засаг даргын зүгээс шагнаж урамшуулах ажлыг журмаар зохицуулна. | Сургалтын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, сургалтын чанар дээшилсэн арга замыг тодорхойлно. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | БСУГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 129 | 3 | ЗГҮАХ 3.2.6 АЗДҮАХ-ийн 2.2.5 | Дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулж, эрүүл, аюулгүй, ээлтэй орчныг бүрдүүлэх | 2017-2018 оны хичээлийн жилд дотуур байрны 30 багш, нийт 1191 суралцагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Эцэг эхийн нөөц бололцоо хүчин чадалд тулгуурлан өрөө тасалгааны нөхцөлийг сайжруулж байна. | Дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулахад эцэг эх, олон нийтийн байгууллагын оролцоо нэмэгдсэн байна. | Сурагчдын аяа тухтай амьдрах, сурч хөгжих нөхцөлийг сайжруулах хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна. | Орон нутгийн төсвийн болон төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, БСУГ |
| 130 | 4 | ЗГҮАХ 3.2.10 АЗДҮАХ-ийн 2.2.9 | Зарим сургууль, цэцэрлэгийн цахим орчныг сайжруулж, “SMART” буюу ухаалаг сургалтын технологийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх | БСШУСЯ, БНСУ-ын Жэжү тусгай мужийн Боловсролын газартай энэ чиглэлээр хамтран ажиллаж байна. | Сүхбаатар сумын 2, 4 дүгээр сургууль цахим тоног төхөөрөмжөөр хангагдаж, “Ухаалаг анги” нээгдэн, үйл ажиллагаа жигдэрсэн байна. | Мэдээллийн технологи ашиглаж, сургалтын үйл ажиллагааг сайжирсан банйа. | Төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, БСУГ |
| 131 | 5 | АЗДҮАХ-ийн 2.2.10 | Зарим сургуулиудын мэдээллийн болон технологийн кабинетыг тохижуулж, сургалтын орчныг сайжруулах | 2017-2018 оныхичээлийнжилд стандартыншаардлагахангасан 358 кабинетадсургалтынүйлажиллагаагзохионбайгуулжбайна. | Сургалтын орчныг сайжруулж, мэдээллийн технологийн болон технологийн кабинет тус бүр 1,1-ийг байгуулсан байна. | Сургалтын таатай орчин бүрдүүлж, сурагчдын сурч, хөгжих боломжийг бүрдүүлэхэд ахиц гаргасан байна. | Орон нутгийн төсвийн болон төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, БСУГ |
| 132 | 6 | АЗДҮАХ-ийн 2.2.11, 2.2.12 | Бүх сургууль, цэцэрлэгийг “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” болох хөдөлгөөнд хамруулж, хүнсний ногооны болон байгалийн ухааны туршилтын талбай, | 13 цэцэрлэг, 10 сургууль “Эрүүл мэндийг дэмжигч аймгийн шилдэг сургууль, цэцэрлэг”-ээр шалгарсан. 15 цэцэрлэг, 10 сургууль, ногооны | “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”, хүнсний ногооны болон байгалийн ухааны туршилтын талбай, хүлэмжтэй сургууль, цэцэрлэгийн тоо | Хүүхдийн сурч хөгжих эрүүл, аюулгүй орчин, эрүүл зан үйл төлөвшүүлэх, тогтвортой хөгжлийн боловсрол олгох боломж бүрдэнэ. | Орон нутгийн төсвийн болон төсөл, хөтөлбөр, хандив, тусламжийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, БСУГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүлэмжтэй болгох ажлыг эрчимжүүлэх | талбайтай байна. | нэмэгдсэн байна. | | |
| 133 | 7 | АЗДҮАХ-ийн 2.2.4 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оношлох, нөхөн сэргээх, эмчлэх үйлчилгээг нэвтрүүлэх, багш, эцэг эхийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйд сургах | 33 сургуульд 237, 22 цэцэрлэгт 58 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч, 155 багш ажиллаж байна. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нар дутагдалтай, тусгайлан бэлтгэгдээгүй, урамшуулал, цалин хангалтгүй байна. | Сургууль, цэцэрлэгүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд ахиц гаргасан байна. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурах, хөгжихөд ахиц гарсан байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, БСУГ |
| 134 | 8 | АЗДҮАХ-ийн 2.6.6 | “Ахмадын зөвлөх үйлчилгээний баг”-ийг ажиллуулан үр дүнг тооцох | Ахмад багш нарын холбоо, сургууль, цэцэрлэг бүрт ахмадын зөвлөл ажиллаж байна. | Ерөө, Бэлчир бүсэд зөвлөн тусалж ажилласан байна. | 3 үеийн залгамж холбоог бэхжүүлэн, залуу багш, удирдах ажилтнуудын ажлын дадлага, туршлага, мэргэжлийн ур чадвар дээшилсэн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, БСУГ, ХХҮГ |
| 135 | 9 | АЗДҮАХ-ийн 2.2.13 | Их, дээд сургуулиудын салбар анги хичээллүүлэх саналыг дэмжиж, иргэдийн аймагтаа дээд боловсрол эзэмших боломж, нөхцөлийг бүрдүүлэх | Их, дээд сургуулийн салбар сургууль байгуулах хүсэлт ирээгүй боловч салбар анги хичээллүүлж байгаа их, дээд сургуулиуд байна. | Салбар анги хичээллүүлэхээр хүсэлт ирүүлсэн их, дээд сургуультай хамтран ажилласан байна. | Иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн боловсролын үйлчилгээг үзүүлсэн байна. | Төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, БСУГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 136 | 10 | АЗДҮАХ-ийн 2.2.8, НБХ-ийн санал | “Багш, сурагч солилцоо” хөтөлбөрийг хэрэгжүүлж,ОХУ, БНХАУ, БНСУ, Япон улсуудтай багш нарыг чадавхжуулах чиглэлээр хамтран ажиллах | “Багш, сурагч солилцоо” хөтөлбөрийн хүрээнд 2018 оны 10 дугаар сарын байдлаар удирдахажилтан-26, багш-445, сурагч-32 хамрагдаад байна. | Багш, сурагч, удирдах ажилтнуудыг гадаад, дотоодод туршлага судлуулах, хамтран ажиллах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | Хамтын ажиллагаа өргөжиж, багш нарын заах арга зүй, ур чадварт байна. | Орон нутгийн төсвийн болон төсөл, хөтөлбөр, хандив, тусламжийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, БСУГ |
| 137 | 11 | АЗДҮАХ-ийн 2.2.7 НБХ-ийн санал | Насан туршийн боловсролын иргэдэд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх | 2017-2018 оны хичээлийн жилд Насан туршийн боловсролын нэгжүүд 235 төрлийн 394 удаагийн сургалтыг 20308 хүнд зохион байгуулж, төсвөөс-1523800, төсөл хөтөлбөрөөс-602800, хандив тусламжийн 1416500 төгрөгийг зарцуулсан байна. | Насан туршийн боловсролын 6 чиглэлийн сургалтыг зохион байгуулж, сургалтад хамрагдах хүний тоог нэмэгдүүлсэн байна. | Иргэдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, насан туршийн боловсрол олгоход ахиц гарсан байна. | Орон нутгийн төсвийн болон төсөл, хөтөлбөр, хандив, тусламжийн хөрөнгөөр | БСУГ, Насан туршийн боловсролын төв |
| 138 | 12 | НБХ-ийн санал | Хөрөнгө оруулалтын чуулга уулзалтаар гэрээ болон санамж бичиг байгуулсан дотоод, гадаадын их дээд сургуультай хамтын ажиллагааг эхлүүлэх | Хөрөнгө оруулалтын чуулга уулзалтыг зохион байгуулж санамж бичиг, гэрээ байгуулсан. | Гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран ажиллана. | Мэргэжилтэй ажилтны тоо нэмэгдэж, чадварлаг ажиллах хүчин бий болж сурагчдын мэдлэг чадвар дээшилсэн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, БСУГ |
| **2.3 Биеийн тамир, спортын бодлого** | | | | | | | |
| **Нийтийн биеийн тамир, спортын хүний нөөц, дэд бүтцийг сайжруулж, үндэсний спортын өв соёлыг уламжлуулан нийтийн хүртээл болгох, иргэдийг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 139 | 1 | АЗДҮАХ-ийн 2.3.1 | Багш, дасгалжуулагчдыг чадваржуулах сургалтанд хамруулах | 2018 онд Улсын болон аймгийн чанартай 7 сургалтанд 80 гаруй багш дасгалжуулагчдыг хамруулсан. | Улсын болон аймгийн чанартай 9 сургалтанд давхардсан тоогоор 100 гаруй арга зүйч, багш, дасгалжуулагчид хамрагдсан байна. | Арга зүйч, багш дасгалжуулагчдын заах арга зүй, ур чадвар сайжирч, багш дасгалжуулагчдын өрсөлдөх чадвар нэмэгдэнэ. | Улсын болн орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, БТСГ |
| 140 | 2 | АЗДҮАХ-ийн 2.3.2. | Зарим сумдад спорт цогцолбор, заал, шинээр барьж, шаардлагатай, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах | Аймгийн хэмжээнд бүх сумд наадмын талбайтай, 6 спорт цогцолбортой. | Зарим сумдад сургуулийн спорт заалны барилга баригдсан байна. | Иргэдийн бие бялдрыг хөгжүүлж, спортоор хичээллэгсдийн тоо нэмэгдэнэ. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, БТСГ |
| 141 | 3 | АЗДҮАХ-ийн 2.3.5 | Үндэсний сур, бөх, шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах | Үндэсний спортын 11 удаагийн тэмцээнийг зохион байгуулж, 745 тамирчин оролцсон. | Үндэсний спортын тэмцээн, уралдаанд оролцох иргэд, тамирчдын тоо нэмэгдсэн байна. | Үндэснийспортынсоёлыгөвлүүлэн уламжлуулахажилд ахицгарна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, БТСГ |
| 142 | 4 | АЗДҮАХ-ийн 2.3.4 | Сүхбаатар суманд 2 дугаар сургуулийг түшиглэн хөлбөмбөгийн талбай байгуулах, сум, тосгон, багийн төвд спортын болон хүүхдийн тоглоомын талбайг байгуулж, гэрэлтүүлэг, орчны тохижилтын ажлыг хийх | Сүхбаатар сумын 4 болон 8-р багт сагсан бөмбөгийн талбай, 2, 3, 6 дугаар багт тоглоомын талбай, Шаамар сумын 2 багт сагсан бөмбөг болон хүүдийн тоглоомын талбай, Сайхан суманд тоглоомын талбай байгуулсан. | Бүтээн байгуулалтын ажил хийгдэж, Сүхбаатар суманд хөлбөмбөгийн талбайтай болсон байна. | Хүүхэд залуучуудын чөлөө цагаа өнгөрөөх орчин бүрдэж, бие бялдрыг хөгжүүлж, спортоор хичээллэгсдийн тоо нэмэгдэнэ. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, БТСГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 143 | 5 | АЗДҮАХ-ийн 2.3.7 | Өсвөр үеийн аймгийн шигшээ багийн спортын төрлийг нэмэгдүүлж, амжилт гаргасан тамирчдад дэмжлэг үзүүлэх | Аймгийн хэмжээнд Шатар, бокс, таеквондо, жудо, чөлөөт бөх, волейболийн 6 шигшээ баг хичээллэж байна. | Спортын шигшээ багийг ширээний теннис төрлөөр нэмэгдүүлнэ. | Өндөр зэрэгтэй тамирчдын чансаа өсөж өрсөлдөх чадвар нэмэгдэнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, БТСГ |
| 144 | 6 | НБХ, БТСГ-ын санал | Иргэд хүүхэд багачуудыг усан спортоор хичээллүүлж, усан спортын аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах | Усан бассейны ус эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангуулж үйл ажиллагааг нь эхлүүлэн 2018 онд усан спортоор хичээллэгсэд 430 байгаагаас 30 гаруй нь секц дугуйланд тасралтгүй хичээллэж байна. | Усан бассейны эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангаж үйл ажиллагаа тогтмолжсон байна. | Усан спортоор хичээллэгсдийн тоо нэмэгдсэн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, БТСГ |
| 145 | 7 | АЗДҮАХ-ийн 2.3.8 | “Сэлэнгэ-бага олимп” спортын олон төрөлт арга хэмжээг зохион байгуулах | “Сэлэнгэ-бага олимп” зохион байгуулагдаагүй. | Аймгийн хэмжээний ерөнхий боловсролын сургуулийн сурагчид хамрагдсан байна. | Уралдаан тэмцээний тоо нэмэгдэж, хүүхэд багачуудынбие бялдрыг хөгжүүлэн өрсөлдөх чадвар нэмэгдэнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, БТСГ |
| 146 | 8 | АЗДҮАХ-ийн 2.3.9 | Спортын зарим төрлүүдээр улсын болон бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг аймагтаа зохион байгуулах | Улсын болон бүсийн аварга шалгаруулах 6 тэмцээнийг зохион байгуулж нийт 1020 гаруй тамирчин хамрагдсан. | Улсын болон бүсийн аварга шалгаруулах 1-2 тэмцээн зохион байгуулна. | Тамирчдын ур чадвар нэмэгдэнэ. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, БТСГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 147 | 9 | НБХ-ийн санал | Аймгийн төвд тэшүүрийн талбай, зарим сумдад цанын бааз байгуулах ажлыг эхлүүлэх | Өвлийн спортыг хөгжүүлэх материаллаг бааз байхгүй. | Сүхбаатар төвд тэшүүрийн талбай, зарим сумдад цанын бааз байгуулагдсан байна. | Өвлийн спортоор хичээллэх нөхцөл бүрдэж, хичээллэгсдийн тоо нэмэгдсэн байна. | Олон улсын төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, БТСГ |
| 148 | 10 | НБХ-ийн санал | Аймгийн Засаг даргын нэрэмжит цомын төлөөх тэмцээнийг хэлтэс, агентлаг болон сумдын төрийн албан хаагчдын дунд зохион байгуулах | Жил бүр аймгийн Засаг даргын нэрэмжит спортын арга хэмжээг зохион байгуулан хэвшээд байна. | Аймгийн Засаг даргын нэрэмжит тэмцээнийг өндөр түвшинд бүх сумдыг хамруулан зохион байгуулсан байна. | Төрийн албан хаагчдын эрүүл, аж төрөх зан үйлд сургах ажилд ахиц гаргана. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг сумын ЗДТГ, БТСГ |
| 149 | 11 | НБХ-ийн санал | Аймгийн хэмжээнд тогтмол цагт биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийх аяныг өрнүүлэх | Хилийн 0101-р анги Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Дархан-Сэлэнгийн Цахилгаан түгээх сүлжээ ХК, Төрийн банк, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын нийт 7 байгууллага тогтмол цагт дасгал хөдөлгөөн хийж хэвшсэн. | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төр төсвийн байгууллагууд дасгал хөдөлгөөнийг хийж хэвшсэн байна. | Дасгал хөдөлгөөнөөр хичээллэгсдийн тоо нэмэгдэж, халдварт бус өвчнөөс сэргийлнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, БТСГ |
| **2.4. Соёл, урлагийнбодлого** | | | | | | | | |
| **Үндэсний өв соёлыг хөгжүүлэх, өвлөн уламжлах, сурталчлах, соёл урлагийн аялал жуулчлал, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 150 | 1 | Мэргэжлийн урлагийн байгууллагын санал | Атар газар эзэмшсэний 60 жилийн ойд зориулсан шинэ уран бүтээл туурвиж олны хүртээл болгох | Атрын 60 жилийн ой 2019 онд тохионо. | “Сэлэнгийн долгио” болон “Мөнгөн хараа” чуулга хамтран ойд зориулсан уран бүтээл туурвиж, олны хүртээл болгосон байна. | Иргэдэд бахархах сэтгэл төрж, атар газар эзэмшсэн түүх соёлын мэдлэг дээшилсэн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио” чуулга Дуу бүжгийн “Мөнгөн хараа” чуулга |
| 151 | 2 | ЗГҮАХ 3.2.47 АЗДҮАХ-ийн 2.4.2 | “Өргөн Сэлэнгэ” уран бүтээлийн уралдаан зохион байгуулах | 2018 онд зохион байгуулахаар төлөвлөсөн боловч хөрөнгийн асуудлаас болж хойшлогдсон. | Нутаг орны тухай уран бүтээлийн тоо нэмэгдэж, урын сан баяжигдана. | Гадаад, дотоодод орон нутгаа сурталчилж, соёлын аялал жуулчлал хөгжинө. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, БСУГ |
| 152 | 3 | ЗГҮАХ 3.2.47 АЗДҮАХ-ийн 2.4.2 | “Эв мод”-ны наадам зохион байгуулах | ОХУ-ын Буриад улстай уламжлалт хамтын ажиллагааны хүрээнд 2 жил тутамд байгуулж байна. | Хөрш зэргэлдээ, найрамдалт харилц аатай улс, орны хамтын ажиллагаа сайжирна. | Үндэсний соёл урлагаа сурталчилж, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгж |
| 153 | 4 | НБХ-ийн санал | Иргэдийн дунд ном унших аян зарлаж, явуулын болон зөөврийн номын сангийн үйлчилгээний чанарыг сайжруулах | “Номын баяр”, “Үндэсний бичиг үсгийн баяр” зэрэг 10 гаруй арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулдаг. | “Номын солилцоо”, “Номын өдөрлөг”, “Айл бүрт номын сан” зэрэг аян, арга хэмжээнүүдийг зохион байгуулагдсан байна. | Уншигчдын тоо нэмэгдэж, номоор дамжуулж соёлтой иргэнийг төлөвшүүлнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Нийтийн номын сан |
| 154 | 5 | НБХ-ийн санал | Хамтын ажиллагаатай улс орнуудад зохион байгуулагдах урлагийн наадам, соёлын арга хэмжээнд уран бүтээлчид, ардын авъяастан, хүүхэд | БНХАУ, Япон, ОХУ, БНСУ зэрэг улс оронтой хамтран ажиллах гэрээ байгуулж, санал хүргүүлсэн. | Олон Улсын урлагийн их наадамд авяаслаг хүүхэд багачууд, уран бүтээлчдийг оролцуулсан байна. | Үндэсний өв соёлоо сурталчилж, уран бүтээлчид, ардын авъяастан, хүүхэд багачуудын авъяас чадварыг | Аймаг, сумын төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, Мэргэжлийн байгууллагууд |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | багачуудыг оролцуулахад дэмжлэг үзүүлэх | | | хөгжүүлнэ. | | |
| 155 | 6 | НБХ-ийн санал | Иргэний нийгмийн байгууллагууд болон чөлөөт уран бүтээлчдийг дэмжиж, хамтран ажиллах | Соёл урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллагууд, чөлөөт уран бүтээлчдийн судалгаа хийсэн. | Иргэний нийгмийн байгууллагууд, чөлөөт уран бүтээлчидтэй гэрээ байгуулж, хамтран ажиллана. | Иргэдийн соёл урлагийн үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна. | Аймаг, сумын төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, БСУГ |
| 156 | 7 | БСУГ-ын санал | Сэлэнгэ нутгийн тухай уран бүтээлийг баримтжуулах, клипжүүлэх ажлыг зохион байгуулах | Заавал сурах дууг сонгон аймгийн ИТХТ-ийн тогтоолоор батлуулсан. | Орон нутгаа сурталчилж, уран бүтээлчдийг дэмжинэ. | Нутаг орноороо бахархах, хөгжил, дэвшилд иргэдийн идэвхитэй оролцоог нэмэгдүүлнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, БСУГ, “Сэлэнгийн долгио” чуулга |
| 157 | 8 | БСУГ-ын санал | Соёлын байгууллагуудын түүх, биет болон биет бус өвийн тухай зурагт ном, хэвлүүлэх | Аймгийн Нэгдсэн музейгээс 1 ном хэвлүүлсэн. | Судалгаа хийж номын эх бэлтгэлийг хийнэ. | Соёлын салбарын түүх, өвийг сурталчилж, эдийн засгийн эргэлтэнд оруулж, өвлөн уламжлагчдыг дэмжинэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | БСУГ, Аймгийн Нэгдсэн музей |
| 158 | 9 | ИТХТ-ийн санал | Ардын хувьсгалтай холбоотой музейн үзмэрийг баяжуулж, музейн барилгын засвар тохижилтийн ажлыг хийх | Музейн барилгын дээврийг зассан. | Музейн барилгад засвар тохижилтийг хийж, ардын хувьсгалтай холбоотой үзмэрийг баяжуулсан байна. | Үйлчилгээний орчин сайжирч, үзэгчдийн танин мэдэхүйн боловсрол дээшилнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | АЗДТГ, Аймгийн Нэгдсэн музей |
| **2.5. Гэрбүл, эмэгтэйчүүд, хүүхэд, залуучуудынбодлого** | | | | | | | | |
| **Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, төрөлх нутгаараа бахархах, түүх, ёс заншил, уламжлалт соёлоо дээдлэх, амьдралын арга ухаанд сургах замаар өрсөлдөх чадвартай, хөдөлмөрч, хүмүүнлэг иргэнийг төлөвшүүлнэ.** | | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 159 | 1 | АЗДҮАХ-ийн 2.5.1. | “Бид Сэлэнгийн ирээдүй”, “Залуус”, “Жаргалтай гэр бүл” аймгийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах | Хөтөлбөрийг 2019 оноос хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. | Хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүнг тооцсон байна. | Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжил хамгааллын үйлчилгээний хүртээмж сайжирна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ГБХЗХГ |
| 160 | 2 | Хүүхэд хамгааллын үндэсний Хөтөлбөр | “Хөгжилд хүүхдийн оролцоо VIII” аймгийн хүүхдийн нэгдсэн чуулган зохион байгуулах | “Хөгжилд хүүхдийн оролцоо VII” аймгийн хүүхдийн чуулганаас 4 чиглэлд 20 санал санаачлага, уриалга гарч одоогийн байдлаар 40 хувьтай хэрэгжиж байна. | Орон нутгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүний ивээл дор сумдын “Хүүхдийн чуулган”-ыг зохион байгуулж нийт 1000 гаруй хүүхдийг хамруулж ажиллана. | Чуулганы шийдвэрийг хэрэгжүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн сурагчдын 20 хувьд хүрч ажиллана. | Аймгийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, ГБХЗХГ |
| 161 | 3 | - | “Байгаль дахь сургалтын төв”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулж хүүхдийн амьдрах ухаан, бие даан хөгжих боломжийг бий болгох | Хүүхдийн хөгжил хамгаалал, оролцоо нэмэгдсэн. | Хүүхдийн хөгжил оролцоог дэмжиж, зуны сургалт, нөлөөллийн ажил тогтмолжино. | Ахлах ангийн сурагчдын мэдлэг, чадвар, хандлагыг нэмэгдүүлнэ. | Төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр | ГБХЗХГ |
| 162 | 4 | АЗДҮАХ-ийн 2.5.9 | Алтанбулаг, Мандал, Сайхан сумдын “Түр хамгаалах байрны үйл ажиллагааг дэмжиж, арга зүйгээр хангаж ажиллах | Түр хамгаалах байрны үйл ажиллагаа тогтмолжоогүй байгаа. | Хүчирхийлэлд өртөгсдийн тоог бууруулж, сэтгэл зүй, хуулийн зөвлөгөө өгч, үйл ажиллагаа тогтмолжино. | Гэр бүл, хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ГБХЗХГ, ЦГ |
| 163 | 5 | Хүүхэд хамгааллын үндэсний хөтөлбөрийн 4 дүгээр зорилт | Хүүхдийн хөгжил, хамгааллын “Жишиг сургууль” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, арга зүйгээр дэмжих | Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуульд хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлж байна. | Хүүхдийн хөгжил, хамгааллын бодлого, хөтөлбөрийг жишиг байдлаар туршин хэрэгжүүлэх арга зүй, мэдлэгийг | Сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын тогтолцоо бэхжиж, хүүхдийн эрхийн | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ГБХЗХГ, БСУГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэмэгдүүлнэ. | зөрчил буурах, бодит нөхцөл бүрдэнэ. | | |
| 164 | 6 | АИТХ-ын Төлөөлөгчийн санал | “Хүүхэд хүмүүжүүлэх зөрэг арга” эцэг, эхийн сургалт, зөвлөгөөн, нөлөөллийн ажлуудыг шат дараатай зохион байгуулах | Эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, хүүхдийн сурах, амьдрах таатай орчинг бүрдүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж байна. | Насанд хүрээгүй хүүхдийн гэмт хэргийн гаралт буурна. | Эцэг эхийн оролцоо нэмэгдэж, эрсдлээс урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарсан байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, БСУГ, ЦГ |
| 165 | 7 | Хүүхэд хамгааллын үндэсний хөтөлбөрийн 1.2.6 | Дэлгэцийн донтолт, архи, тамхи, мансууруулах бодисын хор нөлөө, хүчирхийлэл, дарамт, шахалт, эрсдэлд өртөхөөс сэргийлэх талаар хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан сургалт, нөлөөллийн ажил өрнүүлэх | 2018 онд дэлгэцийн донтолт, мансууруулах бодисын хэрэглээ ихсэж, 2017 оныхоос өссөн дүнтэй байна. | Дэлгэцийн дондолт, архи тамхи, мансууруулах бодисын хор нөлөө, хүчирхийллийн тоог бууруулна. | Хүүхдийг хорт зуршил, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарсан байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ГБХЗХГ |
| **2.6.Хөдөлмөр эрхлэлт, нийгмийнхамгаалал** | | | | | | | | |
| **Зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвар, мэргэшилтэй ажилтнуудыг бэлтгэх, шинээр ажлын байр бий болгох замаар өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |
| 166 | 1 | АЗДҮАХ-ийн 2.6.1 | Ажил олгогч орон нутгийн байгууллагуудын ажлын байрны захиалгыг авч нэгтгэх, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, ажилд зуучлах | 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 233 ажил олгогчоос ирүүлсэн 970 ажлын байранд 821 иргэнийг ажилд зуучилсан. | 1000 иргэн ажилд зуучлагдсан байна. | Ажилтай болсон иргэдийн тоо нэмэгдсэнээр өрхийн орлого дээшилнэ. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ХХҮГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 167 | 2 | АЗДҮАХ-ийн 2.6.3 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх ажил зохион байгуулж үр дүнг тооцох | 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 1654 иргэнийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт, нийтийг хамарсан ажилд хамруулж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 715,3 сая төгрөгийг зарцуулсан. Сэлэнгэ аймагт оны эхний 9 сарын 25-ны байдлаар шинээр 716 ажлын байр бий болсны 244 нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, төсөл хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд бий болсон. | Шинэ ажлын байр бий болсон байна. | Иргэдийн өрхийн орлого нэмэгдэнэ. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ХХҮГ |
| 168 | 3 | АЗДҮАХ-ийн 2.6.4 | Аймгийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аймгийн дэд хөтөлбөр батлагдан гарч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдан аж ахуйн нэгж байгууллага болон 17 сум 6 тосгонд хүргэж хэрэгжилтэнд хяналт тавин | Аж ахуйн нэгж байгууллагуудын ажлын нөхцөл, эрүүл аюулгүй орчин бүрдэж, аймгийн хөтөлбөр хэрэгжсэн байна. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөл буурч ажилчдад эрүүл, аюулгүй ажиллах зан үйл хэвшинэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ХХҮГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажиллаж байна. | | | | |
| 169 | 4 | АЗДҮАХ-ийн 2.6.14 | Зорилтот бүлгийн айл өрхүүдийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төсөл, хөтөлбөрийн хүрээнд амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний 4 төсөл хөтөлбөрт 6 өрхийн 29 иргэнийг хамруулж нийт хөдөлмөрийн насны 17 иргэнийг байнгын болон түр ажлын байраар хангасан. | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний 40 төсөл хөтөлбөрт 60 өрхийн иргэдийг хамруулж хөдөлмөрийн насны иргэдийг байнгын болон түр ажлын байранд зуучилна. | Зорилтот бүлгийн айл өрхүүдийн орлого нэмэгдсэн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | ХХҮГ |
| 170 | 5 | Ажлын хэсгийн санал | Япон Улсын Шизуоки мужтай хамтран хүлэмжийн аж ахуйд дадлагажигч ажилтан ажиллуулах ажлыг эхлүүлэх | Япон Улсын Шизуоки мужтай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд дадлагажигч ажилтан ажиллуулахаар тохирсон болно. | Япон Улсын Шизуоки мужид дадлагажигч ажилтнаар иргэд ажлын байранд зуучилсан байна. | Иргэдийн хүлэмжийн аж ахуй эрхлэх туршлага нэмэгдэж, өрхийн орлого дээшилсэн байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ХХҮГ |
| 171 | 6 | ХХҮГ-ын санал | Баянгол сумын ахмадын сувиллын тоног төхөөрөмж, эд хогшил тавилгыг шинэчилж, Сүхбаатар сумын ахмадын сувиллын барилгад их засвар хийх | Баянгол сумын ахмадын сувлал нь нэг ээлжиндээ 10, Сүхбаатар сумын ахмадын сувилал 20 ахмад настанг амрааж сувилах хүчин чадалтай бөгөөд 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 15 ээлжээр 450 ахмад настан амрааж 94.7 сая төгрөгийн орлого бүрдүүлэн ажилласан. | 2019 онд 21 ээлжээр 630 ахмад настанг амрааж сувилуулсан байна. | Ахмад настнууд ая тухтай орчинд амарч сувилуулан, нийгмийн халамжийн хүртээмж сайжирсан байна. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ХХҮГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 172 | 7 | НБХ-ийн санал | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбарзөвлөлийг9 хүнийбүрэлдэхүүнт эйгээрбайгуулж, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн хөтөлбөр төлөвлөгөө хэрэгжсэн байна. | Зөвлөлийн үйлажиллагаатог тмолжсонбайна. | - | Аймаг, сумдын ЗДТГ, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбарзөвлөл |
| 173 | 8 | НБХ-ийн санал | Аймгийн Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт салбар хорооны арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Аймгийн Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт салбар хорооны хамтын гэрээг байгуулж, арга хэмжээний төлөвлөгөөг баталсан. | Гэрээг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Хөдөлмөр эрхлэгчдийн эрх ашиг хангагдсан байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, Аймгийн Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт салбар хороо |
| 174 | 9 | АЗДҮАХ-ийн 2.6.15 | Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил уурхайчдыг сайн дурын даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлэх | 2018 оны 09 дүгээр сарын байдлаар малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгч 1118 иргэн шинээр сайн дурын даатгалд хамрагдсан байна. | 2019 онд 1300 малчин болон хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил уурхайчдыг шинээр сайн дурын даатгалд хамруулсан байна. | Малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн баталгаа дээшилсэн байна. | - | Сумдын ЗДТГ, НДХ |
| 175 | 10 | АИТХурлаас гарсан санал | Аймгийн болон сумдын ахмадын хорооны дарга нарт урамшуулал олгох | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 47 тоот тогтоол батлагдаж | Аймаг сумын ахмадын хорооны дарга нар урамшуулалд хамрагдсан байна. | Аймаг сумын ахмадын хорооны үйл ажиллагаанд ахиц гарч, ахмад настны өрхийн | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | урамшуулал олгох эрх зүйн орчин бүрдсэн байна. | | орлого нэмэгдэнэ. | | |
| **ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО:** | | | | | | | | |
| **3.1.Төрийн захиргааны бодлого:** | | | | | | | | |
| 176 | 1 | АЗДҮАХ-ийн 3.1.16 | “Сэлэнгэ шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх | Ардын хувьсгалын 100, аймаг байгуулагдсаны 90 жилийн ойг угтаж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | Хөтөлбөрийг боловсруулж хэрэгжилт, үр дүнг тооцож эхэлнэ. | Ардын хувьсгалын 100, аймгийн 90 жилийн ойн арга хэмжээг угтсан бүтээн байгуулалтууд хийгдэж, иргэдийн амьдрах орчин нөхцөл сайжирсан байна. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн болон хувийн хэвшлийн байгууллагууд |
| 177 | 2 | АЗДҮАХ-ийн 3.1.14 | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргах СӨГ-ын хэмжээ сүүлийн 3 жилийн байдлаар буураагүй байна. 2015 онд 21530, 2016 онд 25395, 2017 онд 29911 СӨГ ирсэн байна. | Аймгийн хэмжээнд төр төсвийн байгууллагуудад иргэдээс ирүүлэх санал өргөдөл гомдлын хувь буурсан байна. | Санал өргөдөл гомдол хуулийн хугацаандаа бодитой шийдвэрлэгдэнэ. | Аймаг, сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ |
| 178 | 3 | АЗДТГ-ын даргын санал | Иргэдэд эерэг хандлага бий болгох нөлөөллийн арга хэмжээг төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах | Төрийн байгууллагаас явуулж буй бодлого, шийдвэр, үйл ажиллагааны талаарх иргэд, олон нийтийн сөрөг хандлага байсаар байна. | Иргэдэд чиглэсэн нөлөөллийн олон талт арга хэмжээ зохион байгуулагдсан байна. | Иргэдийн ухамсарт нөлөөлж эерэг хандлага бий болох эхлэл тавигдана. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, ЕБС, Иргэний нийгмийн байгууллагууд |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 179 | 4 | ТЗУХ-ийн санал | Төрийн албанд шинээр орсон албан хаагчдад чиглүүлэх сургалт зохион байгуулах чиглэлийг боловсруулж, хэрэгжүүлэх | Аймгийн ИТХТ-ийн 2017 оны 143 дугаар тогтоолоор “Суралцагч байгууллага- Төрийн албаны манлайлал хөтөлбөр” батлагдсан. | Төрийн албанд шинээр томилогдсон иргэдийг ажлын байран дээр сургах арга зүй, чиглэлтэй болно. | Шинээр томилогдсон албан хаагчид ажлын байрандаа дадлагажиж, ажлын бүтээмж нэмэгдэнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл |
| 180 | 5 | ТЗУХ-ийн санал | “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам” боловсруулах нийтлэг арга зүйг боловсруулж, төрийн байгууллагуудад нэвтрүүлэх | Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгах явцад төрийн байгууллагуудын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын боловсруулалт, хэрэгжилт хангалтгүй байсан. | Нэгдсэн арга зүйтэй болсон байна. | Байгууллагын дотоод журам шинэчлэгдэж, хөдөлмөрийн харилцааны зохицуулалт сайжирна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл |
| 181 | 6 | АЗДҮАХ-ийн 3.1.19 | Аймгийн гадаад арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх | Аймгийн ИТХТ-ийн 2017 оны 142 дугаар тогтоолоор “Сэлэнгэ аймгийн Гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр” батлагдсан. | Гадаад хамтын ажиллагаа өргөжиж, үр өгөөж нэмэгдэнэ. | Уламжлалт харилцаанаас гадна хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр шинэ түншлэл нэмэгдэж, аймаг, муж, хотуудын соёл урлаг, боловсрол, спорт, эрүүл мэнд, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлчилгээний эдийн засгийн үр нөлөө дээшилнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллагууд |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 182 | 7 | ТЗУХ-ийн санал | Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын албан хаагчдын төлөөллийг хамтын ажиллагаатай гадаадын улс орнуудад туршлага судлах, сургах ажлыг зохион байгуулах | Аймгийн ИТХТ-ийн 2017 оны 142 дугаар тогтоолоор “Сэлэнгэ аймгийн Гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр”, 2018 оны 17 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хөтөлбөр” тус тус батлагдсан. | Аймаг, орон нутгийн албан хаагчдын төлөөлөл туршлага судалж, хэрэгцээт сургалтанд хамрагдсан байна. | Гадаад улс орны ижил төстэй байгууллагуудад хэрэгжүүлж буй тэргүүн туршлагаас суралцаж, аймгийн хүний нөөцийн чадавх бэхжинэ. | Орон нутгийн төсвий хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн болон хувийн хэвшлийн байгууллагууд |
| 183 | 8 | АЗДҮАХ-ийн 3.1.15 | Аймгийн “Алдартнуудын нэрэмжит шагнал”-ын шалгуур үзүүлэлтийг батлуулж, хэрэгжүүлэх | Аймгийн ИТХТ-ийн 2017 оны 134 дүгээр тогтоолоор “Аймгийн ИТХ, Засаг даргаас олгох шагналын журам” батлагдсан. | Журмын 2.2, 3.2 дахь заалтууд хэрэгжинэ. | Нэрэмжит шагнал бий болж, иргэдийн нийгмийн идэвх оролцоонд түлхэц бий болно. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн болон хувийн хэвшлийн байгууллагууд |
| 184 | 9 | ТЗУХ-ийн санал | “Эмх цэгц” төрийн албаны архив, албан хэрэг хөтлөлтийн аяныг нийт төр, төсвийн байгууллагын хэмжээнд зохион байгуулж, үр дүнг тооцох | Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгах явцад төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн стандартын хэрэгжилт хангалтгүй байсан. | Аяны удирдамж, төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангана. | Төрийн албаны албан хэрэг хөтлөлтийн стандартын хэрэгжилт сайжирна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллагууд |
| 185 | 10 | АЗДҮАХ-ийн 3.1.3 | Төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр үзүүлэх үйлчилгээний хүрээг өргөжүүлж, багуудад хүрч | 2016 онд Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд 7 байгууллагын 47 төрөлд давхардсан тоогоор нийт 29626 иргэнд төрийн | Үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж дээшилнэ. | Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаа тогтворжиж, иргэдийн сэтгэл ханамж | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, ТҮНТ-д үйлчилгээ үзүүлдэг хэлтэс, агентлагууд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үйлчлэх | үйлчилгээ, сургалт сурталчилгаа үзүүлсэн байна.2017 оны III улирлын байдлаар 8 байгууллагын 52 төрөлд 21342 иргэнд төрийн үйлчилгээ үзүүлсэн. | | дээшилнэ. | | |
| 186 | 11 | ТЗУХ-ийн санал | Сумдад цахим хурлын төхөөрөмжийг суурилуулан цаг үеийн шуурхай хурал болон сургалт зохион байгуулах | 2018 онд ГОУХАН-т “Цахим орчныг сайжруулах төсөл”-ийг боловсруулан танилцуулагдсан. Төслийн газраас тендер зарлаж шалгаруулна. | Сумдад цахим хурлын төхөөрөмжүүд суурилуулагдан цахим хурал болон сургалтууд хийгдсэн байна. | Цаг үеийн асуудлаар цаг хугацаа орон зайнаас үл хамааран цахим хурлыг зохион байгуулах боломж бүрдэнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ |
| 187 | 12 | АЗДҮАХ-ийн 3.1.3 | Төрийн үйлчилгээний “Хур” системийг зарим сумдад нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх | Аймгийн хэмжээнд Сүхбаатар, Мандал, Сайхан, Ерөө суманд ТҮЦ машин ажиллуулж байна. Цаашид улсын хэмжээнд тус системийг нэвтрүүлэх талаар Засгийн газрын шийдвэр гарсан. | Зарим сумдад төрийн үйлчилгээний “Хур” системийг нэвтрүүлсэн байна. | Иргэдэд төрийн үйлчилгээ цаг хугацаа орон зайнаас үл хамааран түргэн шуурхай, хүртээмжтэй хүрэх нөхцөл бүрдэнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ |
| 188 | 13 | НБХ-ийн санал | Төрийн үйлчилгээний албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулах | Сүүлийн жилүүдэд зохион байгуулагдсан сургалт, зөвлөгөөнд төрийн захиргааны албан хаагчид түлхүү хамрагдсан байна. | Төрийн албаны холбогдолтой шинээр батлан гарсан хууль, тогтоомж, шийдвэрийн талаар мэдлэг олгосон байна. | Төрийн үйлчилгээний албан хаагчдын чадавхи бэхжинэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 189 | 14 | АЗДТГ-ын даргын санал | “Төрийн албаны удирдах ажилтны улсын зөвлөгөөн”-өөс гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлж, үр дүнг тооцон, холбогдох дээд шатны байгууллагад тайлагнах | 2018 оны 9 дүгээр сарын 21-22 өдрүүдэд УБ хотод “Төрийн албаны удирдах ажилтны улсын зөвлөгөөн” зохион байгуулагдаж нэгдсэн зөвлөмж гаргасан. | Зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнг тооцсон байна. | Төрийн албаны ажил үйлчилгээнд ахиц гарсан байна. | - | Аймгийн ЗДТГ |
| 190 | 15 | АЗДҮАХ-ийн 3.1.5 | Хүний нөөцийн бодлого, төлөвлөлтөд төрийн албаны чадахуйн /мерит/ тогтолцоог хэрэгжүүлж, төрийн албаны мэргэшлийн шалгалт болон удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр нээлттэй, ил тод зохион байгуулах | Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 14 тоот тогтоолоор удирдах ажилтны сонгон шалгаруулалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 тоот тогтоолоор төрийн жинхэнэ албанд анх удаа орох мэргэшлийн шалгалтыг тус тус өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан цахим хэлбэрээр зохион байгуулж байна. | Төрийн албаны сул орон тоог мерит зарчмын дагуу хэрэгжүүлэхээр төсвийн шууд захирагч нарт үүрэг болгож, төрийн жинхэнэ албанд анх удаа орох мэргэшлийн шалгалтыг шаардлага хангасан түвшинд зохион байгуулж, хүний нөөцийн томилгооны зөрчилгүй аймаг болно. | Төрийн байгууллагуудад чадахуйн /мерит/тогтолцоонд тулгуурласан хүний нөөцийн бодлого, төлөвлөлт хэрэгжинэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, Төрийн албаны салбар зөвлөл |
| 191 | 16 | АЗДҮАХ-ийн 3.1.7 | Төрийн зарим байгууллагад Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлж, баталгаажуулалтын | Аймгийн хэмжээнд чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2008стандартыг аймгийн ЗДТГ, СХЗХ үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. | Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна. | Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд чанарын өөрчлөлт гарч, иргэдийн сэтгэл ханамж | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, төрийн зарим байгууллагууд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гэрчилгээ авах | ISO 9001:2015 стандартыг аймгийн ЗДТГ, СХЗХ, Орхонтуул сумын ЗДТГ хэрэгжүүлж байна. | | дээшилнэ. | | |
| 192 | 17 | АЗДҮАХ-ийн 3.1.8 | Аймаг, сумдын албан ёсны цахим хуудасны мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, тасралтгүй ажиллагааг хангах | Аймгийн 17 сум, 6 тосгонг албан ёсны цахим хуудастай болгож, ашиглалтанд өгсөн боловч үйл ажиллагаа хангалтгүй байна. | Албан ёсны цахим хуудасны ашиглалт сайжирч, тогтмолжсон байна. | Мэдээ мэдээллийн хүртээмж нэмэгдэнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ |
| 193 | 18 | АЗДҮАХ-ийн 1.4.13 | Ерөө сумын Бугант тосгоныг шилэн кабельд холбох ажлын тооцоо судалгааг гарган дээд шатны байгууллагад уламжлах | Аймгийн хэмжээнд нийт 16 сум, 5 тосгон шилэн кабельд холбогдсон. Хушаат сумыг шилэн кабельд холбох ажил хийгдэж байгаа бөгөөд 2018 онд багтаан ашиглалтанд авна. | Судалгаа тооцоо хийгдэж, санал уламжлагдсан байна. | Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээнд холбогдсоноор интернетийн хэрэглээний хүртээмж нэмэгдэж, сум, тосгодын иргэд мэдээллийг түргэн шуурхай авах боломж бүрдэнэ. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ |
| 194 | 19 | АЗДҮАХ-ийн 3.1.20 | Зарим улс, хот, муж, Элчин Сайдын Яамд, хөтөлбөрийн газруудаас хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний үр өгөөжийг нэмэгдүүлэхэд хамтран ажиллах | Сэлэнгэ аймаг нь 10 гаруй гадаадын улс орон, хот муж, 10 гаруй элчин сайдын яам, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаатай ажиллаж байна. | Хамтын ажиллагааны гэрээ болон төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлсэн байна. | Гадаад хамтын ажиллагаа шинэ шатанд хүрнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, төр, төсвийн байгууллагууд |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 195 | 20 | АЗДҮАХ-ийн 3.1.20 | Зүүн Хойд Азийн бүс нутгийн Засаг захиргаадын холбооны үйл ажиллагаанд идэвх санаачлагатай оролцож, аймаг, орон нутгаа Олон Улсын түвшинд сурталчилж ажиллах | Тус холбоонд 2006 онд элсэж, гадаад харилцаа, эдийн засаг, гамшгаас хамгаалах гэх мэт 4 удаагийн арга хэмжээнд жил бүр тогтмол оролцож байна. | Олон Улсын түвшинд аймаг орон нутгаа сурталчлах арга хэмжээг хэрэгжүүлж, зохион байгуулагдах арга хэмжээнүүдэд идэвхитэй оролцоно. | Холбооны худалдаа, эдийн засаг, шинжлэх ухааны хамтын ажиллагаа өргөжинө. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ |
| **3.1.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажил үйлчилгээ:** | | | | | | | | |
| 196 | 1 | АЗДҮАХ-ийн 3.1.4 | “Багийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 51 тоот тогтоолоор тус хөтөлбөрийг батлуулж, хэрэгжүүлж эхэлсэн.<br>2018 онд нийт тосгодын захирагч, багийн Засаг дарга нарт тоног төхөөрөмж олгон, эрүүл мэндийн үзлэгт хамруулж, тосгодын уулзалтыг зохион байгуулсан. | 2019 онд тус хөтөлбөрт туссан зарим арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны хэрэгжилтийг 30 хувьд хүргэнэ. | Аймаг, сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ |
| 197 | 2 | | Түнхэл, Бугант, Номгон тосгодыг сум болгох асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад уламжлах | Бугант тосгонд “Тосгодын тулгамдсан асуудал түүнийг шийдвэрлэх арга замууд” сэдэвт хэлэлцүүлэгийг зохион байгуулж, | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тус сумдын холбогдох материалуудыг хэлэлцүүлж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт | Холбогдох хууль тогтоомжийн шаардлага хангасан материалыг дээд шатны байгууллагад уламжилсан | - | Аймаг, сумын ЗДТГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тус тосгодын захирагч нарын сум болох хэрэгцээ шаардлагын талаар илтгэл мэдээллийг сонсож, иргэдийн саналыг авсан. | уламжлана. | байна. | | |
| 198 | 3 | - | Аймгийн Засаг даргын 2.4 жилийн үйл ажиллагааны тайланг дүрст хэлбэрээр бэлтгэж иргэд, байгууллагад сурталчлах | Аймгийн Засаг даргын 1.6 жилийн ажлын тайланг дүрст хэлбэрээр бэлтгэн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөд танилцуулж, орон нутгийн “Миний Монгол”, “Таны Сэлэнгэ” телевизүүдэр дамжуулж, нийтийн хүртээл болгосон. Мөн тус тайланг сумдад хүргүүлж, аймгийн хэмжээний томоохон арга хэмжээний үеэр оролцогчдод мэдээлж байна. | Сүүлийн үеийн дуу дүрсний шинэлэг програм хангамжуудыг ашиглан хийж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, үнэлгээ дүгнэлт авна. | Иргэд, олон нийтэд сурталчилан таниулна. | Аймаг, сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ |
| 199 | 4 | - | Сэлэнгэ аймгийн дүрст танилцуулгыг Монгол, Англи хэл дээр бэлтгэж нийтийн хүртээл болгох | Аймгийн танилцуулгыг 2014 оноос хойш шинэчлээгүй байна. | Эдийн засаг, нийгмийн холбогдох үзүүлэлт, статистик мэдээ мэдээллийг шинэчлэн баяжуулна. | Иргэд, олон нийтэд сурталчилан таниулна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ |
| 200 | 5 | - | Аймаг, орон нутгийн онцлогийг | Ардын хувьсгалын 97 жил, Сэлэнгэ | Төв, орон нутгийн телевизээр орон | Аймгийн дүрс бичлэгийн | Орон нутгийн төсвийн | Аймгийн ЗДТГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | илтгэсэн “Сэлэнгийн өнгө” тусгай сурвалжлага, цуврал баримтат нэвтрүүлэг, видео киног бэлтгэж нийтийн хүртээл болгох | аймаг байгуулагдсаны 87 жилийн ойн баяр наадмын хүрээнд “Наадмын өнгө” нэртэй 1 нэвтрүүлэг, 1 нийтлэлийг бэлтгэж Монцамэ агентлаг, Таны Сэлэнгэ телевизээр нийтийн хүртээл болгосон. | нутгийн онцлогийг харуулсан сурвалжлага, нэвтрүүлэгийг нийтийн хүртээл болгоно. | архивтай болж, иргэд олон нийтийг орон нутгийн мэдээллээр хангана. | хөрөнгөөр | |
| 201 | 6 | АЗДҮАХ-ийн 3.1.14 | Аймгийн Засаг даргын Нэрэмжит үзлэг, Зөвлөн туслах ажлын хэсэг болон дээд шатны байгууллагуудаас гаргасан шийдвэрүүдийг үндэслэн төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудад ажлын хэсэг ажиллуулж, үр дүнг тооцох | Аймгийн Засаг даргын 2013 оны А/449 дүгээр захирамжаар төрийн байгууллагуудад “Нэрэмжит үзлэг” болон зөвлөн туслах ажлын хэсгийг ажиллуулж байна.<br>Мөн дээд шатны байгууллагуудаас гаргасан шийдвэрүүдийг үндэслэн 2018 онд нийт 12 ажлын хэсгийг сум, агентлагт ажиллуулсан. | Нутгийн захиргааны байгууллагын 2018 оны үйл ажиллагааны үр дүнг үндэслэн сум, агентлагт аймгийн Засаг даргын “Нэрэмжит үзлэг” зохион байгуулж, “Зөвлөн туслах” ажлын хэсгийг ажилуулсан байна. | Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа сайжирч, иргэдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ |
| 202 | 7 | АЗДҮАХ-ийн 3.1.14 | Төрийн байгууллагуудын үйлчилгээний чанар, үр дүнгийн талаар иргэдээс | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор хэрэглэгчийн үнэлгээг | Шинэчлэн хийсэн аймгийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан цахим хэлбэрээр санал | Иргэдээс ирүүлсэн шинэ санал хүсэлтийг төрийн байгууллагуудын ажил | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | санал асуулгыг цахим хэлбэрээр болон хөндлөнгийн байгууллагуудтай хамтран авч, үр дүнг тооцох | хөндлөнгийн байгууллагаар хийлгэхээр шийдвэрлэж, хэрэглэгчийн үнэлгээ хийх ерөнхий удирдамжийг ирүүлсэн. | асуулга авч үнэлгээ, дүгнэлт өгөх. Хөндлөнгийн байгууллагаар хийлгэх хэрэглэгчийн үнэлгээнд насанд хүрсэн иргэдийн 3-5 хүртэлх хувийг хамруулна. | үйлчилгээнд хэрэгжүүлж, төр, иргэний хамтын ажиллагааг бэхжүүлнэ. | | |
| 203 | 8 | Ажлын хэсгийн санал | “Ээлтэй үйлчилгээ-Иргэн танд” нээлттэй хаалганы өдөр арга хэмжээг нийт сум, суурин газарт зохион байгуулах | Нээлттэй хаалганы өдөр арга хэмжээ нь 2017, 2018 онд төлөвлөгдсөн боловч хийгдээгүй. | Нийт сум, тосгодод хуваарийн дагуу зохион байгулагдаж иргэдэд хэрэгцээт төрийн үйлчилгээг хүргэсэн байна. | Төрийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, иргэдийн сэтгэл ханамж дээшилнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, холбогдох агентлагууд |
| 204 | 9 | АЗДҮАХ-ийн 3.1.11 | “Түүхийн он дараалын бичээс” эмхэтгэлийг гаргаж олон нийтийн хүртээл болгох ажлыг үргэлжлүүлэх | 2017 онд “Өргөн Сэлэнгэ” сэтгүүлийн 4-р улирлын дугаартай хамтатган гаргасан. 2018 оны 12 сард хийж гүйцэтгэхээр эх бэлтгэлийн ажил хийгдэж байна. | Аймгийн нийгэм эдийн засгийн баримт бичгүүдийн хэрэгжилт, төсвийн гүйцэтгэл, тухайн оны тэмдэглэлт болон онцлох ажлуудыг багтаасан эмхтгэлийг боловсруулж нийтэд хүргэх | Иргэд олон нийтийг орон нутгийн мэдээллээр хангаж, архвивын баримтанд баяжилт хийгдэнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, холбогдох агентлагууд |
| 205 | 10 | АЗДҮАХ-ийн 3.1.17 | ГОУХАН-ИЙН ЭТИС-3 хөтөлбөрийн газартай хамтран “Тогтвортой аялал жуулчлал, түншлэлийн үнэ цэнэ” төслийг хэрэгжүүлэх | Тус онд төслийн санхүүжилтээр нийт 5 төрийн албан хаагч 1 бизнес эрхлэгчийг Тайланд улсад чиглүүлэгчээр бэлтгэсэн. Төслийн газартай хамтран Шаамар | “Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг төслийн газартай хамтран хэрэгжүүлнэ. | Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын чадавхи сайжирна. | - | Аймгийн ЗДТГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сумын Дулаанхаан тосгоны “Хөвчит нум” нөхөрлөлд нутгийн иргэдийг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэхээр сонгон авч 2018 оны 5 сард сургах чадавхжуулах ажлыг зохион байгуулж, 9-р сарын 10-11-ний өдрүүдэд турших аялал хийсэн. | | | | |
| 206 | 11 | - | “Тогтвортой хөгжил-Түншлэл” хамтын ажиллагааны зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, сум бүрт салбар зөвлөлийг байгуулах | Аймгийн ИТХТ-ийн 2018 оны 9-р сарын 96 дугаар тогтоолоор 15 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөл байгуулагдсан. | Зөвлөлийн үйл ажиллагаа жигдэрч, сумдад салбар зөвлөл байгуулагдсан байна. | Орон нутгийн тогтвортой хөгжлийн зорилго, зорилтууд хэрэгжиж, үр дүнд хүрсэн байна. | - | “Тогтвортой хөгжил-Түншлэл” хамтын ажиллагааны зөвлөл |
| 207 | 12 | АЗДҮАХ-ийн 3.1.13 | Төрийн байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд дотоод аудитыг зохион байгуулж, үр дүнг тооцох | Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу аймгийн “Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад дотоод | 2-оос доошгүй байгууллагад "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулна. | Байгууллагын ажил үйлчилгээнд чанарын өөрчлөлт гарна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | аудит хийх журмын” дагуу хяналт шалгалт хийнэ. | | | | |
| 208 | 13 | - | “Тогтвортой амжиргаа-3” төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Тогтвортой амжиргаа 1, 2 төслүүд хэрэгжсэн. 2016 оноос Тогтвортой амьжиргаа-3 төсөл хэрэгжиж эхэлсэн. | Төрийн албан хаагч болон малчид, тариаланчид зэрэг зорилтот бүлгийн иргэдийг чадавхижуулах ажлыг зохион байгуулсан байна. | Иргэд, төрийн албан хаагчдын мэдлэг, чадвар дээшилж, оюуны хөрөнгө оруулалт хийгдсэн байна. | Төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, Тогтвортой амжиргаа -3 төсөл |
| **3.1.3.Гамшиг осол, батлан хамгаалах, хяналт шалгалтын ажил үйлчилгээ** | | | | | | | | |
| 209 | 1 | АЗДҮАХ-ийн 3.1.25 | Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд эрсдэл бүхий сумдын байгаль хамгаалагч, ойн санг гэрээгээр эзэмшигч, ойн нөхөрлөлд цагдаагийн газартай хамтран сургалт зохион байгуулах, урьдчилан сэргийлэх ажлыг хамтран зохион байгуулах | 2017, 2018 онд ой хээрийн түймрийн улмаас их хэмжээний хохирол учирсан. | Ой хээрийн түймрийн гаралт багасаж, урьдчилан сэргийлэх ажил хийгдсэн байна. | Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх иргэд, холбогдох албаны хүмүүсийн мэдлэг, мэдээлэл нэмэгдэж, ой хээрийн түймрийн гаралт буурсан байна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ОБГ, ЦГ |
| 210 | 2 | АЗДҮАХ-ийн 3.1.25 | “Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв” байгуулах | Улсын Онцгой комиссын дарга, ОБЕГ-ын даргаас 2018 оны 1-р улиралд 21 аймгийн ОБГ-т аймаг орон нутгийн | Аймгийн 2019 оны төсөвт суугдсанаар Онцгой байдлын газар шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвтэй болсон байна. | Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аюулт үзэгдэл, ослын үед шуурхай удирдлагаар | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, ОБГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дэмжлэгтэйгээр шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвтэй болох үүрэг чиглэл өгөгдсөн. | | хангах, мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүлээн авах, дамжуулна. | | |
| 211 | 3 | АЗДҮАХ-ийн 3.1.22 | Хэмжил зүйн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж шатахуун түгээгүүрийг баталгаажуулах зориулалтын хэмжих хэрэгсэл бүхий автомашинаар хангахад дэмжлэг үзүүлэх | Шатахуун түгээх газруудын шатахуун түгээгүүрүүдийг баталгаажуулахад MNS 3015:2014 шалгах аргын стандартыг мөрддөг бөгөөд тус стандартад заасанаар шалгалтын багаж хэрэгсэлд ± 0,1% алдаатай 5, 10, 20, 50, 100 литрийн багтаамжтай эталон мерник ашиглах ёстой гэж заасан байдаг. Өндөр хурдтай шахах түгээгүүрийг шалгах эталон мерник байхгүйгээс орон нутагтаа баталгаажуулах боломгүй байна. | Шатахуун түгээгүүрийг баталгаажуулах зориулалтын хэмжих хэрэгсэл бүхий автомашинаар хангагдсан байна. | - Иргэд болон нефтийн бүтээгдэхүүн борлуулагч нарын сэтгэл ханамж дээшилж, хэрэглэгч, үйлчлүүлэгчийн харилцан итгэлцлийг дээшлүүлнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, СХЗХ |
| 212 | 4 | АЗДҮАХ-ийн 3.1.22 | Нефт, хийн түгээгүүрт зориулсан ареомертийн цуглуулга бүхий хэмжих хэрэгслээр хангах | Байгаль орчинд нүүрстөрөгч бага ялгаруулдаг, байгальд ээлтэй технологи бий болгох,хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах эдийн засгийн үр | Эталон хэмжүүртэй болсноор ороннутгынхаахийн түгээгүүрийгбаталгаажуулдагболж, хэмжүүрийннэртэр өлөснө. | Нүүрстөрөгч бага ялгаруулдаг,байгальд ээлтэй технологи бий болгох, хүлэмжийн хий ялгаралтыг бууруулах эдийн засгийн үр | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ, СХЗХ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | өгөөжийг нэмэгдүүлэх, Засгийн газрын зорилтын хүрээнд байгуулагдан ажиллаж буй ГАЗ-ын шатахуун түгээх станцыг шалгаж баталгаажуулах шаардлагатай байна. | | өгөөжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна. | | |
| 213 | 5 | АЗДҮАХ-ийн 3.1.24 | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх мэргэжлийн зөвлөгөө дэмжлэгээр хангах, сургалт зохион байгуулах | 2018 онд 9 сарын байдлаар төлөвлөгөөт болон зөвлөн туслах үйлчилгээнд 918 байгууллага, аж обьектийг хамруулж, төлөвлөгөө 91 хувьтай байна. | 2019 онд хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээнд 800 гаруй объектыг хамруулсан байна. | Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын тоо багасна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | МХГ |
| 214 | 6 | АЗДҮАХ-ийн 3.1.24 | Мэргэжлийн хяналтын Улсын байцаагчийн ёс зүйг чанд сахиулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах | Жил бүр зохион байгуулдаг аймгийн Нээлттэй хаалганы өдөр арга хэмжээний үеэр иргэдээс авдаг санал асуулгын үр дүнгээр тус байгууллагын ажилтан албан хаагчдын харилцаа, ёс зүйн талаар бухимдалтай | Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн ёс зүйн хэмжээг мөрдөж, авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажиллана. | Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны талаархи хэрэглэгчийн сэтгэл ханамж дээшилнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | МХГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгаа талаар иргэд ихээхэн санал ирүүлдэг. | | | | |
| 215 | 7 | АЗДҮАХ-ийн 3.1.26 | Батлан хамгаалах салбарын хууль эрх зүйн, бодлогын шинэчлэлийн талаар сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах | 2018 оны сайдтайбайгуулсан гэрээндтусгагдсан 5 бүлэг 42 нэр төрлийн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэн ажиллаж байна. | Шинэчлэн батлагдсан Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс болон бусад хууль тогтоомжуудыгорон нутагтсурталчилсан байна. | Хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийн талаар иргэдийн мэдлэг дээшилнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ |
| 216 | 8 | Цэргийн Штабын санал | Аймгийн цэргийн сургалт явуулах хичээлийн танхим, хээрийн сургалтын төвтэй болох талаар холбогдох байгууллагатай хамтарч ажиллах | Аймгийн цэргийн сургалт явуулах хичээлийн танхим, хээрийн сургалтын төв байхгүй байна. | Онолын мэдлэг, хээрийн сургалт, дадлага зохион байгуулах сургалтын төвтэй болсон байна. | Батланхамгаалахчиглэлээргарсанхуультогтоомжийнбиелэлтийгороннутагтхангах, тайванболононцгойнөхцөлийнүед иргэдэдмэргэшил, аргазүйн, туслалцааүзүүлэх,дайчилгааныбэлтгэлнөөцийнбүрэлдэхүүнийсургалтыгороннутагтзохионбайгуулах нөхцөл бүрдэнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ |
| 217 | 9 | Цэргийн Штабын санал | Цэргийн дүйцүүлэх албыг сурталчлах, алба хааж байгаа иргэдийг орон нутгийн бүтээн байгуулалт, бусад арга хэмжээнд татан оролцуулах | 50 иргэн цэргийн дүйцүүлэх албанд үүрэг гүйцэтгэж байна. | 2019 онд нийт 30 иргэнийг цэргийн дүйцүүлэх албанд авсан байна. | Иргэд цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу орон нутагтаа биечлэн хаахыг зэрэгцээ орон нутгийн бүтээн байгуулалт, байгалийн гамшиг, хорио | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, ОБГ, ХХТХЗ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цээрийн дэглэм сахиулах, хил хамгаалах зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байна. | | |
| 218 | 10 | АЗДҮАХ-ийн 3.1.26 | Цэргийн насны залуучуудын боловсролыг дээшлүүлж, эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж үр дүнг тооцох | Цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж буй залуучуудын 82 орчим хувь эрүүл мэндээр тэнцэхгүй байна. Залуучуудын 90-ээд хувь нь 2 ба түүнээс дээш хавсарсан өвчлөлтэй байна. | Эрүүл мэнд, Боловсролын байгууллагатай хамтран лекц, семинар зохион байгуулсанаар цэргийн насны залуучуудын боловсрол, эрүүл мэндийн түвшинд ахиц гарна. | Залуучуудын боловсролын түвшин ахиж, өвчлөлийг эрт үед нь илрүүлж, хүндрэлээс сэргийлж, өвчлөлийг бууруулна. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ, БСУГ, ЭМГ |
| 219 | 11 | АЗДҮАХ-ийн 3.1.26 | Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл, хүмүүжил олгож, төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах | Сүхбаатар сумын Үндэсний лаборатори сургуулийн төгсөх ангийн сурагчдад өнөөгийн Зэвсэгт хүчний бодлого, Энхийг дэмжих ажиллагаа, ҮБХИС-ийн тухай танилцуулга хийсэн. | Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл, хүмүүжил олгож, төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулан эх оронч үзэл сурталыг нэмэгдүүлнэ. | Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд нөлөөлөл үзүүлнэ. | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумын ЗДТГ |
| 220 | 12 | АЗДҮАХ-ийн 3.2.10 | Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн үйл ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах ажлыг зохион байгуулж, хилийн бүсийн бэлчээрийг иргэдэд ашиглуулах талаар | Одоогоор ХХТХЗөвлөлийн үйл ажиллагаанд жилд дунджаар 1-3 сая төгрөгийн хөрөнгө зарцуулагддаг боловч энэ нь хүрэлцдэггүй. | ХХТХЗөвлөлийн үйл ажиллагаа шинэ шатанд гарч зохион байгуулж, хилийн бүсийн бэлчээрийг иргэдэд ашиглуулах талаар судалж, холбогдох байгууллагад уламжилсан байна. | Хил орчмын гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурч, иргэд, байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирсан байна. | - | Аймаг, сумын ЗДТГ, Хилийн 0101, 0243-р анги, ХХТХЗ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | судалж, холбогдох байгууллагад уламжлах | | | | | |
| **3.2.Хүний эрхийг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинэлэг арга хэлбэрээр үр дүнтэй хэрэгжүүлж, хууль, эрх зүйн ажил үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.** | | | | | | | | |
| **3.2.1.Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийг хангах, авлигаас урьдчилан сэргийлэх ажил, үйлчилгээ** | | | | | | | | |
| 221 | 1 | АЗДҮАХ-ийн 3.2.1, Хууль эрх зүйн хэлтсийн санал | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний болон аймгийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж, хууль тогтоомжийн сургалт, хэлэлцүүлэг, сурталчилгааны ажлыг төлөвлөгөө, хуваарийн дагуу зохион байгуулах. | Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2018 оны эхний 9 сарын байдлаар 511 удаагийн сургалт, хэлэлцүүлэг, сурталчилгааны ажил зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 29831 иргэнийг хамруулсан. | Хэлэлцүүлэг, сурталчилгааны ажлууд зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 30.000-аас доошгүй иргэдийг хамруулсан байна. | Хөтөлбөрүүд хэрэгжиж иргэдийн эрх зүйн боловсрол дээшилсэн байна. | - | Аймаг, сумдын ЗДТГ, агентлагууд |
| 222 | 2 | Хууль эрх зүйн хэлтсийн санал | Аймагт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн акт, төсөл, хөтөлбөр тухайн орон нутгийн төрийн байгууллагаас нийтэд үзүүлж буй төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг “E-khutuch” эрх зүйн туслалцааны цахим хуудсанд бүрэн байршуулах ажлыг зохион байгуулах | Цахим хуудсыг ашиглалтанд оруулахаар бэлтгэл ханган, туршилтийн шатандаа явагдаж байна. | 2019 онд цахим хуудсыг ашиглалтанд оруулж аймагт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн акт, төсөл, хөтөлбөр тухайн орон нутгийн төрийн байгууллагаас нийтэд үзүүлж буй төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг бүрэн оруулсан байна. | Цахим хуудсаар дамжуулан иргэдэд зөвлөгөө, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх боломж нөхцөл бүрдсэн байна. | - | Аймаг, сумдын ЗДТГ, агентлагууд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 223 | 3 | АЗДҮАХ-ийн 3.2.2 | Аймгийн Засаг даргын хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд гаргах шаардлагатай захиргааны хэм хэмжээний актуудыг батлан гаргаж, мөрдүүлэх | 2017 оны байдлаар аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан 3 хэм хэмжээний акт улсын бүртгэлд бүртгэлтэй байна. | Аймгийн Засаг даргын хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд гаргах шаардлагатай хэм хэжээний актуудыг батлан гаргасан байна. | Хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирсан байна. | - | Аймаг, сумдын ЗДТГ |
| 224 | 4 | АЗДҮАХ-ийн 3.2.2 | Аймаг, сумдын захиргааны актуудаар цахим сан бүрдүүлж, захиргааны шийдвэрийн хувийн хэрэг бүрдүүлэлтийг шинээр зохион байгуулж, захиргааны актуудын давхардал, зөрчлийг арилган, эрх зүйн баримт бичгийн агуулга, уялдаа холбоог сайжруулах | Захиргааны ерөнхий хуулийн дагуу захиргааны шийдвэрийн хувийн хэрэгтэй байхаар хуульчилж, аймгийн Засаг даргын 2017 оны захирамжаар журам батлагдаж хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн. | Захиргааны актуудаар цахим сан бүрдүүлж, захиргааны шийдвэрийн хувийн хэрэг бүрдүүлэлтийг хийж зөрчил, давхардлыг арилгасан байна. | Аймаг, сумдын захиргааны актууд хувийн хэрэгтэй болж, цахим сан бүрдэж иргэд, албан хаагчид ашиглах нөхцөл бүрдсэн байна. | - | Аймгийн ЗДТГ |
| 225 | 5 | АЗДҮАХ-ийн 3.2.3, Хууль эрх зүйн хэлтсийн санал | Сум, агентлаг, байгууллага, төрийн албан хаагч бүр салбарын хууль тогтоомжийн цаасан болон цахим сан, судалгаа мэдээллийн сантай болох ажлыг гэрээ, төлөвлөгөөнд тусгуулж аймгийн | Төрийн байгууллагууд, албан хаагч нар одоогоор салбарын хууль тогтоомжийн эмхэтгэлүүд болон legalinfo.mn сайтыг ашиглаж байна. | Сум, агентлаг, байгууллага, төрийн албан хаагч бүр хууль тогтоомжийг цаасан болон цахим сантай болсон байна. | Байгууллага бүр хууль тогтоомжийн цаасан болон цахим сантай болж хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирсан байна. | - | Аймаг, сумдын ЗДТГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэмжээнд зохион байгуулах | | | | | |
| 226 | 6 | АЗДҮАХ-ийн 3.2.4 | Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, аймаг сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн дэргэдэх “Иргэний хяналтын зөвлөл”-ийн ажлыг эрчимжүүлж, 2 сум, 3 агентлагт хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгэх | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтээр сум агентлагуудад хөндлөнгийн үнэлгээ хийгдэж байгаагүй. | Авлигаас урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоо нэмэгдэж, хөндлөнгийн хяналттай болсон байна. | Иргэдийн оролцоо нэмэгдэж, хөндлөнгийн хяналттай болж, авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан байна. | - | Аймаг, сумдын ЗДТГ, агентлагууд |
| 227 | 7 | АЗДҮАХ-ийн 3.2.4 | Авлигын эсрэг үндэсний болон аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, "Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй байгууллага, хамт олон" хөдөлгөөнийг өрнүүлж, сайн туршлагуудыг түгээн дэлгэрүүлэх | Үндэсний хөтөлбөр 2016 онд, аймгийн хөтөлбөр 2017 онд батлагдаж, тус аяныг 2017 оны 10 дугаар сараас 2018 оны 10 дугаар сард хэрэгжсэн. | Хөтөлбөрүүд хэрэгжиж төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагаанд ахиц гарсан байна. | Авлигын эсрэг үндэсний болон аймгийн хөтөлбөр хэрэгжиж, авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажиллаж, сайн туршлага бий болсон байна. | - | Аймаг, сумдын ЗДТГ, төрийн бүх шатны байгууллагууд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 228 | 8 | Хууль эрх зүйн хэлтсийн санал | Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2015-2018 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж,2019-2024 оны төлөвлөгөөг боловсруулан аймгийн ИТХ-аар батлуулж, хүний эрхийг хангах олон талт ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах | Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2015-2018 оны төлөвлөгөө хэрэгжиж дууссан. | Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний2019-2024 оны төлөвлөгөөг шинээр боловсруулан аймгийн ИТХ-аар батлуулж, хүний эрхийг зөрчиж буй зөрчлүүдийг арилгах, аюулгүй байдлыг хангах ажил, арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулдаг болж,хүний эрхийн ажил үйлчилгээнд ахиц гарсан байна. | Үндсэн хуулиар олгогдсон хүний эрх, эрх чөлөө хангагдах боломж, нөхцөл бүрдсэнбайна. | - | Аймаг, сумдын ЗДТГ, Хүний эрхийн үндэсний комиссын салбар |
| 229 | 9 | АЗДҮАХ-ийн 3.2.13, Хууль эрх зүйн хэлтсийн санал | Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах байрыг Сайхан суманд байгуулж, ашиглалтанд оруулах | Аймгийн хэмжээнд стандартын шаардлага хангасан хамгаалах байр байхгүй бөгөөд Алтанбулаг, Мандал сумдад 2-3 өрөөг тохижуулан хамгаалах байр болгон ашиглаж байна. | Сайхан сум дахь Цагдаагийн өмчлөлийн холбогдох байрыг засварлаж хамгаалах байр болгосон байна. | Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдаж, гэрч хохирогчийн аюулгүй байдал хангагдах боломж нөхцөл бүрдсэн байна. | - | Аймаг, сумын ЗДТГ, ЦГ |
| 230 | 10 | АЗДҮАХ-ийн 3.1.23 | Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хориглосон үйл | Одоогоор аймаг, сумдад Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөлүүд | Хэрэглэгчийн мэдээллийн төв байгуулагдсан байна. | Хэрэглэгчид мэдээ, мэдээллээ шуурхай авах боломж бүрдэж, хэрэглэгчийн эрх | - | АймгийнЗДТГ, СХЗХ, ХЭХОТБЗ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллагаа, шийдвэр гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ажлыг зохион байгуулж, зарим сумдад хэрэглэгчийн мэдээллийн төв байгуулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх | байгуулагдан ажиллаж байна. | | ашиг хамгаалагдсан байна. | | |
| **3.2.2.Архив, улсын бүртгэлийн ажил, үйлчилгээ** | | | | | | | | |
| 231 | 1 | АЗДҮАХ-ийн 3.2.6 | Төрийн архивын сан хөмрөгийг цахим санд шилжүүлэх ажлыг эрчимжүүлж, цахимжуулалтын ажлыг 80 хувьд хүргэх | Цахимжуулалтын ажил 2017 оны байдлаар 42.6 хувь, 2018 оны байдлаар 58.4 хувьтай байна. Архивын баримт жил бүр тасралтгүй нэмэгдэж байдаг. | Лавлагаа мэдээлэлд ихээр ашиглагддаг 17 хөмрөгийг цахим хэлбэрт шилжүүлж, цахимжуулалтын ажлыг 80 хувьд хүргэнэ. | Архивын үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломж бүрдэж, нээлттэй, хүртээмжтэй, шуурхай болно. | - | Аймгийн ЗДТГ |
| 232 | 2 | АЗДҮАХ-ийн 3.2.6 | Төрийн архивын байрыг зураг төсвийн дагуу бариулах асуудлыг МУЗГ, аймгийн ИТХ-д тавьж шийдвэрлүүлэх | Зориулалтын байргүй, одоогийн байрлаж буй архивын фондод материал нэмж хүлээн авах боломжгүй болсон. | Зураг төсвийн дагуу байр барих хөрөнгийн асуудал шийдэгдсэн байна. | Архивын зориулалтын байртай болох нөхцөл бүрдсэн байна. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймгийн ЗДТГ |
| 233 | 3 | АЗДҮАХ-ийн 3.2.6 | Байгууллагын архивын ORG-AMS программын ашиглалтыг эрчимжүүлж, архивыг цахим хэлбэрт шилжүүлэх, хөмрөг үүсгэгч байгууллагуудын архивын баримтын | Төрийн байгууллагууд архивын ORG-AMS программд баримтын тодорхойлон бичилтийн шивэлтийг хийж байгаа бөгөөд эх баримттай цахим холболт хийх | Байгууллагуудын архивыг цахим хэлбэрт шилжиж, хөмрөг үүсгэгч байгууллагуудын архивын баримтын хадгалалт, хамгаалалт дээшилсэн байна. | Архивын үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх боломж бүрдэж, төрийн үйлчилгээ хүртээмжтэй, шуурхай болно. | - | Аймгийн ЗДТГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг эрчимжүүлэх | боломжгүй байна. | | | | |
| 234 | 4 | АЗДҮАХ-ийн 3.2.7 | Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын цахимжуулалтын ажлыг эрчимжүүлж, иргэний бүртгэлийн онлайн системд холбогдоогүй сумдыг холбох ажлыг зохион байгуулах | Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архив цахимжаагүй. | Аймгийн хэмжээнд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын үйлчилгээг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, сумдыг онлайн системд холбосон байна. | Хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээ чирэгдэлгүй түргэн шуурхай хүрэх нөхцөл бүрдсэн байна. | - | Аймаг, сумдын ЗДТГ, УБХ |
| 235 | 5 | АЗДҮАХ-ийн 3.2.7 | Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн шинэ хуулиудаар сургалт, сурталчилгааны ажлуудыг үе шаттай зохион байгуулах | 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс салбарын шинэ хуулиуд мөрдөгдөж эхэлнэ. | Шинээр батлагдсан хуулиудын сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулагдаж, иргэдийн эрх зүйн мэдлэг, мэдээлэл дээшилсэн байна. | Улсын бүртгэлийн ажил үйлчилгээнд ахиц гарч, төрийн үйлчилгээ түргэн шуурхай үзүүлдэг болсон байна. | - | Аймаг, сумдын ЗДТГ, УБХ |
| **3.2.3.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, үйлчилгээ** | | | | | | | | |
| 236 | 1 | АЗДҮАХ-ийн 3.2.4 | Архидалттай тэмцэх аймгийн хөтөлбөрийг болон тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр батлагдсан үндэсний болон аймгийн хөтөлбөрийг | 2018 оны 9 сарын байдлаар 969 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 18.9 хувиар буурсан байна. | Иргэд эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөл бүрдсэн байна. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар иргэд, олон нийтэд зориулсан мэдээлэл, сурталчилгааны хүртээмж, чанар сайжирч, иргэдийн эрх зүйн мэдлэг | - | Аймаг, сумдын ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, мэдээлэл, сурталчилгааны ажлыг нэмэгдүүлэх замаар гэмт хэргийн гаралтыг бууруулах ажлыг зохион байгуулах | | | дээшилсэн байна. | | |
| 237 | 2 | АЗДҮАХ-ийн 3.2.8 | Аймгийн Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах байр болон Шүүхийн шинжилгээний албаны конторын барилга бариулах асуудлыгсудлан шийдвэрлүүлэх | Аймгийн Цагдаагийн газрын эрүүлжүүлэх, саатуулах байр нь одоогоор тус газрын зоорийн давхарт байрладаг ба байрны нөхцөл муу. Шүүхийн шинжилгээний алба нь одоогоор өөрийн байргүй Нутгийн захиргааны 2 дугаар байранд үйл ажиллагаагаа явуулж байна. | Эрүүлжүүлэх, саатуулах байр барих болон Шүүхийн шинжилгээний албаны конторын барилга бариулах асуудлыг судлан шийдвэрлүүлсэн байна. | Байр барих асуудал шийдэгдсэн байна. | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Аймаг, сумдын ЗДТГ, ЦГ |
| 238 | 3 | АЗДҮАХ-ийн 3.2.8 | Авто замын хурд сааруулагч, замын тэмдэг, тэмдэглэгээгудамж талбайн гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах | Авто замын хурд сааруулагч болон замын тэмдэг, тэмдэглэгээг жил бүр засаж сайжруулан, шинээр тавигдсан зам талбайд тэмдэг, тэмдэглэгээ, гэрэлтүүлэг, камержуулалтыг хийж байна. | Тэмдэг, тэмдэглэгээ, гэрэлтүүлэг, камержуулалт нэмэгдсэн байна. | Гэмт хэргийн гаралт буурсан байна. | - | Аймаг, сумдын ЗДТГ, ЦГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 239 | 4 | АЗДҮАХ-ийн 3.2.8 | Цагдаагийн алба хаагч нарын хээрийн дадлага сургуулилтын төв, “Бялдаржуулах танхим” барих асуудлыг судалж, шийдвэрлүүлэх | Дадлага сургуулилтын төв, бялдаржуулах танхим байхгүй. | Судалж, шийдвэрлүүлсэн байна. | Хээрийн дадлага сургуулилтын төв, “Бялдаржуулах танхим” барих нөхцөл бүрдсэн байна. | | Аймгийн ЗДТГ, ЦГ |
| 240 | 5 | Хууль эрх зүйн хэлтсийн санал | Хууль сахиулах байгууллагуудын сургалт, мэдээллийн нэгдсэн төв байгуулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх | Алтанбулаг сумын ИТХ-ын 2018 оны 44 дүгээр тогтоолоор төв барих 1 га газрын асуудлыг шийдвэрлүүлсэн. | Судалж, шийдвэрлүүлсэн байна. | Хууль сахиулах байгууллагуудын сургалт, мэдээллийн нэгдсэн төв байгуулах нөхцөл бүрдсэн байна. | - | Аймгийн ЗДТГ, ЦГ |
| 241 | 6 | АЗДҮАХ-ийн 3.2.8 | Хутаг-Өндөрийн заставын албан хаагчдын орон сууцанд их засвар хийх, хилчдийн нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх | “Нэг баг-нэг агт”, “Нэг аж ахуйн нэгж-нэг мотоцикль” аян зохион байгуулагдаж 7 агт олгогдсон. Хилийн 0243 дугаар анги 8 айлын, Хилийн 0101 дүгээр анги 14 айлын орон сууцыг тус тус ашиглалтад оруулсан. | “Нэг баг-нэг агт”, “Нэг аж ахуйн нэгж-нэг мотоцикль” аяныг үргэлжилж, хилийн ангиуд агт морь, мотоциклоор хангагдаж, хилчдийн хотхон байгуулагдсан байна. | Улсын хил хамгаалалтад иргэдийн оролцох оролцоо нэмэгдэж, хил орчмын гэмт хэргийн гаралт буурахад эерэг нөлөө үзүүлж, ажилчдын нийгмийн баталгаа хангагдсан байна. | - | Аймаг, сумын ЗДТГ, Хилийн ангиуд, |
| 242 | 7 | АЗДҮАХ-ийн 3.2.8 | Цогцос тээвэрлэх тусгай зориулалтын авто машинтай болоход дэмжлэг үзүүлэх | Зориулалтын цогцос тээвэрлэх машингүй. | Шүүхийн шинжилгээний албанд шаардлагатай тусгай зориулалтын автомашинтай болсон байна. | Тохитой эрүүл аюулгүй орчинд ажиллах орчин нөхцөл бүрдэж, үйлчилгээний чанарт ахиц гарсан байна. | | Аймгийн ЗДТГ, Шүүхийн шинжилгээний алба |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 243 | 8 | АЗДҮАХ-ийн 3.2.8 | Хоригдлыг ажлын байраар хангах, мэргэжлийн дадлага олгох зорилго бүхий мужааны цехтэй болоход дэмжлэг үзүүлэх | Мужааны цех байхгүй. | Орон нутгийн бүтээн байгуулалт, үйлдвэрлэлийн арга хэмжээнд ялтнуудыг татан оролцуулах замаар тэднийг хөдөлмөр эрхлэх боломжоор хангасан мужааны цехтэй болсон байна. | Үйлдвэрлэлийн арга хэмжээнд ялтнуудыг татан оролцуулж хөдөлмөр эрхлэх, цалин хөлс авч, бусдад учруулсан гэм хорын хохирлоо төлөх, ар гэртээ тус нэмэр болох, ажил мэргэжилтэй болох ур чадвар, чадамжтай болсон байна. | - | Аймгийн ЗДТГ, ШШГГ |
| 244 | 10 | АЗДҮАХ-ийн 3.2.8 | Цагдан хорих байрны нөхцөлийг хүний эрхэд нийцүүлэх, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих телехяналтын системийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх | 2013 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдснаас хойш телекамерийн системийг шинэчлээгүй, дээврээс гоожсон ус болон цахилгаанд гарсан гэмтлийн улмаас хяналтын дэлгэцүүд гэмтсэн, хорих өрөөнүүдийн телекамерь хэвийн ажиллах боломжгүй болсон. | Цагдан хорих байрны орчин нөхцөл сайжирч, хоригдол хоригдогсдын дунд үйлдэгдэх гэмт хэргийн тоо буурсан байна. | Цагдан хорих байрны үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлж, хоригдол, хоригдогсдын дундаас орголт болон гэмт хэрэг зөрчил гарахаас урьдчилан сэргийлнэ, хоригдогсдын эрх зөрчигдөхөөс хамгаалагдсан байна. | - | Аймгийн ЗДТГ, ШШГГ |
| 245 | 11 | АЗДҮАХ-ийн 3.2.11 | Мөнгө угаах, хүний наймаа, хар тамхины болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг бууруулах, | 2018 оны эхний 9 сарын байдлаар залилах гэмт хэрэг 40 бүртгэгдсэнээс 10 гэмт хэрэг буюу 25 хувь нь цахим орчинд үйлдэгдсэн | Аймгийн хэмжээнд үйлдэгдэж буй энэ төрлийн гэмт хэргийн гаралт өмнөх оны мөн үеэс буурсан байна. | Иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөл бүрдсэн байна. | - | Аймгийн ЗДТГ, ЦГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх | бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн гаралт өсөх хандлагатай байна. Мансууруулах эм, сэтгэцэт нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 2017 онд 3, 2018 онд 1 бүртгэгдсэн бөгөөд 66.7 хувиар буурсан байна. | | | | |
| 246 | 12 | АЗДҮАХ-ийн 3.2.11 | Гадаадын иргэнд үзүүлэх зарим үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлж, бүртгэл, хяналтыг сайжруулах, гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах | Гадаадын иргэн оролцсон гэмт хэрэг 2018 онд 3, 2017 онд 1, захиргааны зөрчил 2018 онд 36, 2017 онд 27 тус тус бүртгэгдсэн байна. | Бүртгэл, хяналтын үйл ажиллагааг сайжруулж, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулна. | Гадаадын иргэнд үзүүлэх үйлчилгээний чанар, хяналт сайжирч, гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурсан байна. | - | Аймгийн ЗДТГ ГИХГХБДГ |
| 247 | 13 | АЗДҮАХ-ийн 3.2.11 | Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах болон хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэхэд зориулан автомашинтай болох асуудлыг шийдвэрлэх | Хүрээлэн буй орчны эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргийн нөхцөл байдалтай газар дээр очиж ажиллах туулах чадвар сайтай автомашингүй. Мөн шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах алба нь шүүгдэгч, яллагдагчыг тээвэрлэх | Автомашинтай болох асуудлыг судлан шийдвэрлэсэн байна. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарч, гэмт хэргийн гаралт буурсан байна. | - | Аймгийн ЗДТГ, Шүүхийн Тамгын газар, ЦГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | автомашингүй байна. | | | | |
| 248 | 14 | АЗДҮАХ-ийн 3.2.12 | Хүүхдийг гэмт хэрэг зөрчилд өртөхөөс сэргийлэн эрсдэл бүхий байруудыг тодорхойлж, камержуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, сурагчдын эцэг эхийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах олон талт арга хэмжээг зохион байгуулах | ЕБСургуулиудын сурагчдын эцэ гэхийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах зорилгоор сургууль орчмын эргүүлийг тогтмол ажиллуулж байна. Аймгийн хэмжээнд Ерөнхий боловсролын нийт 34 сургуулийн 30 нь, нийт 42 цэцэрлэгийн 35 нь камерын системийг нэвтрүүлэн ашиглаж байна. | Камержуулалт нэмэгдэж, эцэг эхийн оролцоо нэмэгдэж, насанд хүрээгүй хүнээс үйлдэгдэх гэмт хэргийн гаралт буурсан байна. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарч, гэмт хэргийн гаралт буурсан байна. | - | Аймаг, сумдын ЗДТГ, БСУГ |
| 249 | 15 | АЗДҮАХ-ийн 3.2.14 | Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх цэгүүдэд тавих хяналтыг чангатгаж, цэгийн тоог бууруулах бодлого баримталж, хууль бус согтууруулах ундаа худалдаж байгааг таслан зогсоох | Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх цэг 2018 оны 08 дугаар сарын байдлаар 256 байна. | Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх цэгийн тоог 10 хүртэлх хувиар бууруулсан байна. | Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх цэгүүдэд тавих хяналт сайжирч, гэмт хэргийн гаралт буурсан байна. | - | Аймаг, сумын ЗДТГ, МХГ, ЦГ |

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**